

## ЕРӨНХИЙ ХЯНАЛТЫН СОНСГОЛЫН ТАЙЛАН

**Сэдэв:** “Нийслэлийн 2024-2026 оны төсвийн зарцуулалт, хөрөнгө оруулалтын төслүүдийн хэрэгжилт холбогдох хууль тогтоомжид нийцсэн байдал”

**Зохион байгуулсан огноо:**  
2026 оны 06 дугаар сарын 15, 16-ны өдрүүд

НЭГ. ЕРӨНХИЙ СОНСГОЛ ЗОХИОН БАЙГУУЛАХ ҮНДЭСЛЭЛ	2
ХОЁР. ОРОЛЦОГЧДЫН МЭДЭЭЛЭЛ	3
2.1.Оролцогчдын тоо	4
2.2.Илтгэл, танилцуулга хийсэн байгууллага, албан тушаалтан	5
ГУРАВ.СОНСГОЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА	6
ДӨРӨВ.ТӨРИЙН БАЙГУУЛЛАГА, АЛБАН ТУШААЛТНЫ ХИЙСЭН ИЛТГЭЛ, МЭДЭЭЛЛҮҮД БОЛОН ШИНЖЭЭЧИЙН ДҮГНЭЛТ	8
4.1.Улс ба нийслэлийн төсвийн уялдаа	8
4.2.Нийслэлийн төсөв	10
4.3.Нийслэлийн өмчийн оролцоотой хуулийн этгээдүүдийн хэрэгжүүлж буй төслүүдийн цар хүрээ, зарцуулалт, ирээдүйн хөрөнгө оруулалтын нэгдсэн дүн	11
4.4.Шинжээчдийн дүгнэлт	13
4.5.Авлигатай тэмцэх газрын мэдээлэл	17
4.6.Туулын хурдны замын аудит	18
4.7.Зам тээврийн яамны бодлого ба Нийслэлийн зам тээврийн мега төслүүдийн үйл ажиллагааны уялдаа холбоо	19
4.8.Байгаль орчны зөрчил	20
ТАВ.ОРОЛЦОГЧ ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГА, ИРГЭДИЙН САНАЛ, ТАЙЛАР, МЭДЭЭЛЭЛ, БАЙР СУУРЬ	27
5.1.2026 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн санал	27
5.2.2026 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн санал	28
ЗУРГАА.УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮДИЙН АСУУЛТ, ХАРИУЛТ	29
6.1.2026 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн УИХ-ын гишүүдийн асуулт, хариулт	29
6.1.2026 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн УИХ-ын гишүүдийн асуулт, хариулт	30
ДОЛОО.УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮДИЙН БАЙР СУУРЬ	31
7.1.Засаглал, ашиг сонирхлын зөрчлийн талаар	31
7.2.Нутгийн өөрөө удирдах ёс, төсвийн бодлогын талаар	31
7.3.Сонсголын зорилго, улс төржилтийн талаар	32
НАЙМ.СОНСГОЛ ДАРГАЛАГЧИЙН ДҮГНЭЛТ	32
ЕС.ЕРӨНХИЙ ХЯНАЛТЫН СОНСГОЛЫН НЭГДСЭН САНАЛ, ДҮГНЭЛТ	32
ЦААШИД АВАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ САНАЛ	34

## НЭГ. ЕРӨНХИЙ СОНСГОЛ ЗОХИОН БАЙГУУЛАХ ҮНДЭСЛЭЛ

Сүүлийн жилүүдэд нийслэлийн төсвийн хэмжээ эрчимтэй өсөж, хөрөнгө оруулалтын томоохон төсөл, арга хэмжээ хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор төсвийн сахилга бат, санхүүжилтийн эх үүсвэр, төсөл хэрэгжүүлэх үйл ажиллагааны ил тод байдал, үр ашиг, хууль тогтоомжийн хэрэгжилтийн талаар олон нийтийн анхаарал нэмэгдэж, иргэдийн зүгээс мэдээлэл авах, тайлбар сонсох, хяналт тавих шаардлага эрчимжсэн байна. Тухайлбал, нийслэлээс хэрэгжүүлж буй мега төслүүд, түүний дотор “Туулын хурдны зам”, “Сэлбэ дэд төв”, авто зам, инженерийн дэд бүтэц, орон сууцжуулах төсөл болон нийслэлийн өмчит аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаатай холбоотой асуудлаар олон нийтийн зүгээс санал, гомдол, шүүмжлэл өргөн хүрээнд гарч, төсвийн хөрөнгийн үр ашигтай зарцуулалт, шийдвэр гаргах үйл ажиллагааны нээлттэй байдал, хариуцлагын тогтолцоонд үнэлэлт, дүгнэлт өгөх шаардлага үүссэн байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлд төр, түүний байгууллагаас хууль ёсоор тусгайлан хамгаалбал зохих нууцад хамаарахгүй асуудлаар иргэн мэдээлэл хайх, хүлээн авах эрхтэй гэж заасан. Нийтийн өргөдөлд “d-petition” цахим платформуор дамжуулан “Нийслэлийн төсвийн зарлагад хяналт хийх” асуудлаар 2025 оны 08 дугаар сарын 12-ны өдрөөс 9 дүгээр сарын 11-ний өдрийг хүртэл санал авч 13,895 иргэн дэмжин гарын үсэг зурсан.

Энэхүү нөхцөл байдалтай холбогдуулан Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1, 29.2.2, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 119 дүгээр зүйлийн 119.1.2-д заасныг үндэслэн Улсын Их Хурлын гишүүн Ж.Золжаргалаас 2026 оны 05 дугаар сарын 01-ний өдрийн УИХ-03/4801 дүгээр албан бичгээр ерөнхий хяналтын сонсгол зохион байгуулах хүсэлтээ Монгол Улсын Их Хурлын даргад хандаж гаргасан.

Ерөнхий хяналтын сонсгол зохион байгуулахыг дэмжиж Улсын Их Хурлын гишүүн Э.Бат-Амгалан, Д.Батбаяр, Р.Батболд, Ж.Баярмаа, Б.Бейсен, Ш.Бямбасүрэн, Ж.Галбадрах, Г.Ганбаатар, Б.Заяабал, Ч.Лодойсамбуу, С.Лүндэг, Ц.Мөнхбат, Л.Мөнхбаясгалан, Т.Мөнхсайхан, Б.Мөнхсоёл, П.Мөнхтулга, П.Наранбаяр, Б.Пунсалмаа, Л.Соронзонболд, Х.Тэмүүжин, Б.Хэрлэн, Дав.Цогтбаатар, Д.Энхтүвшин, С.Эрдэнэболд, Ж.Золжаргал нарын 25 гишүүн гарын үсэг зурсан байна.

Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2.2-т зааснаар Улсын Их Хурлын 15-аас доошгүй гишүүн хүсэлт гаргасан тохиолдолд Улсын Их Хурлын Ерөнхий хяналтын сонсголыг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд заасны дагуу заавал явуулах бөгөөд энэ дагуу Монгол Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2026 оны 05 дугаар сарын 19-ний өдрийн “Ерөнхий хяналтын сонсголын тов тогтоох, сонсгол даргалагчийг сонгох тухай” 02 дугаар тогтоолоор “Нийслэлийн 2024-2026 оны төсвийн зарцуулалт, хөрөнгө оруулалтын төслүүдийн хэрэгжилт холбогдох хууль тогтоомжид нийцсэн байдал” сэдвээр Ерөнхий хяналтын сонсголыг 2026 оны 06 дугаар сарын 15, 16-ны өдрүүдэд зохион байгуулахаар тогтож сонсгол даргалагчаар Улсын Их Хурлын гишүүн Ж.Золжаргалыг томилсон.

Мөн Төсвийн байнгын хорооны 2026 оны 05 дугаар сарын 19-ний өдрийн 03 дугаар тогтоолоор уг сонсголын бэлтгэл хангах, зохион байгуулах үүрэг бүхий ажлын хэсгийг Улсын Их Хурлын гишүүн Д.Энхтүвшин, Н.Алтаншагай, Р.Батболд, Ж.Баярмаа, Д.Бум-Очир, Б.Заяабал, Ж.Золжаргал, Ч.Лодойсамбуу, П.Сайнзориг, Б.Хэрлэн, Да.Цогтбаатар нарын 11 гишүүний бүрэлдэхүүнтэй байгуулж, ажлын хэсгийн ахлагчаар Улсын Их Хурлын гишүүн Д.Энхтүвшинг томилсон болно.

Ерөнхий хяналтын сонсголыг 2026 оны 06 дугаар сарын 15, 16-ны өдрүүдэд Төрийн ордонд нээлттэй хэлбэрээр зохион байгуулж, Монголын Үндэсний Олон Нийтийн Радио Телевиз болон Улсын Их Хурлын цахим сувгаар шууд дамжуулан олон нийтэд хүргэсэн бөгөөд сонсголын бэрхшээлтэй иргэдийн мэдээлэл авах боломжийг хангах зорилгоор дохионы хэлний орчуулгыг зэрэг хүргэж ажилласан нь төрийн үйл ажиллагааны ил тод байдал, иргэдийн мэдэх эрхийг хангах, парламентын хяналтын үр нөлөөг нэмэгдүүлэхэд чиглэсэн арга хэмжээ болсон юм.

Сонсголын хүрээнд нийслэлийн төсөв, хөрөнгө оруулалтын бодлого, төсөл хэрэгжилтийн талаар төрийн байгууллагуудын тайлан, мэдээлэл, шинжээчдийн дүгнэлт, аудитын байгууллага болон хууль хяналтын байгууллагын мэдээлэл, иргэдийн санал хүсэлтийг нэгтгэн хэлэлцэж, цаашид хууль тогтоомжийг боловсронгуй болгох, төсвийн хяналт, ил тод байдал, хариуцлагын тогтолцоог сайжруулах чиглэлээр санал, дүгнэлт боловсруулах зорилго тавьж ажиллав.

Ерөнхий хяналтын сонсголын явцад нийслэлийн төсөв, хөрөнгө оруулалтын төслүүдийн төлөвлөлт, санхүүжилт, хэрэгжилтийн өнөөгийн нөхцөл байдал, тулгамдсан асуудал, эрх зүйн зохицуулалтын хэрэгжилт, төсвийн тогтвортой байдалд үзүүлж буй нөлөө, төрийн байгууллагуудын чиг үүргийн уялдаа холбоо, засаглалын асуудал, иргэдийн оролцоо, мэдээллийн ил тод байдлын түвшнийг олон талын оролцоотойгоор хэлэлцэн, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар санал, дүгнэлт боловсруулах үндэс бүрдсэн гэж үзэж байна.

## **ХОЁР. ОРОЛЦОГЧДЫН МЭДЭЭЛЭЛ**

“Нийслэлийн 2024–2026 оны төсвийн зарцуулалт, хөрөнгө оруулалтын төслүүдийн хэрэгжилт холбогдох хууль тогтоомжид нийцсэн байдал” сэдэвт Ерөнхий хяналтын сонсголын зарыг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 121 дүгээр зүйлийн 121.2-т “...сонсгол явуулах сэдэв, огноо, оролцогч, ажиглагчийг бүртгэх зарыг Улсын Их Хурлын албан ёсны цахим хуудаст байршуулна...” гэж заасны дагуу 2026 оны 05 дугаар сарын 21-ний өдөр [www.parliament.mn](http://www.parliament.mn) цахим хуудаст байршуулсан.

Оролцогчдыг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 121 дүгээр зүйлийн 121.11-д заасны дагуу “...14-өөс доошгүй хоногийн хугацаанд бүртгэнэ...” гэж заасны дагуу 06 дугаар сарын 10-ны өдрийн 17.00 цаг хүртэл бүртгэлээ.

Сонсголын эхний өдөр буюу 2026 оны 06 дугаар сарын 15-ны өдөр төрийн байгууллагаас 61, иргэн, хуулийн этгээд, төрийн бус байгууллагын төлөөллөөс 19 оролцогч, нийт 80 хүн оролцсон байна. Хоёр дахь өдөр буюу 2026 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн сонсголд төрийн байгууллагаас 61, иргэн, хуулийн этгээд, төрийн бус байгууллагын төлөөллөөс 41 оролцогч, нийт 102 хүн оролцжээ. Ийнхүү

хоёр өдрийн турш нийтдээ 182 оролцогч сонсголд биечлэн оролцож, санал, тайлбар, мэдээлэл өгсөн.

Сонсголд Улсын Их Хурлын гишүүд, Засгийн газрын гишүүд болон холбогдох төрийн байгууллагын удирдлага, албан тушаалтнууд оролцож мэдээлэл өгсөн бөгөөд нийслэлийн төсөв, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилттэй холбоотой асуудлаар тайлбар, мэдээлэл танилцуулсан. Үүнд:

- Монгол Улсын Ерөнхий аудитор болон Үндэсний аудитын газрын төлөөлөл;
- Авлигатай тэмцэх газар;
- Засгийн газрын Хэрэг эрхлэх газар;
- Сангийн яам;
- Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам;
- Зам, тээврийн хөгжлийн яам;
- Нийслэлийн Засаг даргын Тамгын газар;
- Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал;
- Нийслэлийн өмчит аж ахуйн нэгж, төсөл хэрэгжүүлэгч байгууллагууд;
- Төрийн худалдан авах ажиллагааны газар;
- Зам тээврийн хөгжлийн төв;
- Барилгын хөгжлийн төв болон бусад холбогдох байгууллагын төлөөлөл оролцсон болно.

Мөн Төсвийн байнгын хорооны тогтоолоор томилогдсон шинжээчдийн баг нийслэлийн төсөв, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилт, санхүүжилт, эдийн засгийн үр ашиг, худалдан авах ажиллагаа, эрх зүйн зохицуулалтын асуудлаар дүн шинжилгээ хийж, нийт 9 чиглэлийн танилцуулга, дүгнэлт боловсруулан сонсголд танилцуулсан. Шинжээчдийн дүгнэлт нь сонсголын хэлэлцүүлгийн үндсэн мэдээллийн эх сурвалж болж, Улсын Их Хурлын гишүүдийн асуулт, хэлэлцүүлгийн гол агуулгыг бүрдүүлсэн.

Мөн сонсголд иргэний нийгмийн байгууллага, мэргэжлийн холбоод, судлаачид, сэтгүүлчид болон иргэдийн төлөөлөл оролцож, нийслэлийн төсвийн зарцуулалт, хөрөнгө оруулалтын төслүүдийн хэрэгжилттэй холбоотой санал, шүүмжлэл, байр сууриа илэрхийлсэн бөгөөд иргэдээс ирүүлсэн бичгээр болон цахимаар хүргүүлсэн санал, хүсэлтүүдийг сонсголын явцад танилцуулж хэлэлцэв.

Сонсголын оролцогчид нийслэлийн төсөв, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн талаар төр, иргэн, мэргэжлийн байгууллага болон шинжээчдийн байр суурийг нэг дор төвлөрүүлэн хэлэлцэх боломжийг бүрдүүлсэн.

## 2.1.Оролцогчдын тоо

Ангилал	06.15 (1 дэх өдөр)	06.16 (2 дахь өдөр)	Тэмдэглэл
Төрийн байгууллагын төлөөлөл	61	61	Албан тушаалтнууд
ТББ, иргэн, хуулийн этгээд	17–19	40–41	Үг хэлэх эрхтэй
Ажиглагч	1	1	Иргэн
УИХ-ын гишүүд (ирц)	19	16	Байнгын хороод

## **2.2.Илтгэл, танилцуулга хийсэн байгууллага, албан тушаалтан**

Ерөнхий хяналтын сонсголын үеэр холбогдох яам, төрийн болон нийслэлийн байгууллагын сайд, албан тушаалтан болон шинжээчдийн төлөөлөл мэдээлэл, танилцуулга хийж оролцов.

Сонсголын үеэр дараах байгууллага, албан тушаалтнууд үндсэн илтгэл, мэдээллийг хийсэн байна. Үүнд:

<b>№</b>	<b>Танилцуулсан илтгэл</b>	<b>Илтгэгч</b>
<b>2026 оны 6 дугаар сарын 15-ны өдөр</b>		
1	Монгол Улсын төсвийн бодлого ба нийслэлийн төсвийн уялдаа, санхүүжилтийн эх үүсвэр, хууль тогтоомжид нийцсэн эсэх болон анхаарах асуудал (2024-2026)	Сангийн сайд З.Мэндсайхан
2	Нийслэлийн 2024-2026 оны төсөв	Улаанбаатар хотын захирагч Б.Пүрэвдагва
3	Нийслэлийн өмчийн оролцоотой хуулийн этгээдүүдийн (ХК, ХХК, сан, охин ба хараат компани, ОНӨААТҮГ, ОНӨТҮГ) хэрэгжүүлж буй төслүүдийн цар хүрээ, зарцуулалт, ирээдүйн хөрөнгө оруулалтын нэгдсэн дүн	Нийслэлийн өмчийн харилцааны газрын дарга В.Оюумаа
4	Нийслэлийн хөрөнгө оруулалтын төслүүдтэй холбоотой асуудлаар мөрдөн шалгах ажиллагаа явагдаж буй хэргийн талаарх мэдээлэл, нийслэлийн хэмжээнд 2024 оноос хойш хийсэн авлига ашиг сонирхлын зөрчлийн талаарх судалгаа, авсан арга хэмжээний мэдээлэл	Авлигатай тэмцэх газрын дэд дарга Г.Азжаргал, Хяналт шалгалт, дүн шинжилгээний хэлтсийн дарга М.Даваатогтох
<b>2026 оны 6 дугаар сарын 16-ны өдөр</b>		
1	Туулын хурдны замын төсөлд хийсэн аудитын талаар	Монгол Улсын Ерөнхий аудитор С.Магнайсүрэн
2	Туул хурдны замын төслийн хүрээнд хийсэн худалдан авах ажиллагаанд хийсэн дүгнэлт	Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Б.Энхбаяр
3	Туулын хурдны замын төслийн хэрэгжилтийн явцад гарсан зөрчлүүд, авсан арга хэмжээ	Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд Ц.Сандаг-Очир
4	Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам болон Нийслэлийн бүтээн байгуулалтын бодлогын уялдаа холбоо, төслүүдийн хэрэгжилтийг сайжруулах санал, дүгнэлт	Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны Төрийн нарийн бичгийн дарга М.Баяраа
5	Сэлбэ дэд төв орон сууцжуулах төслийн техник эдийн засгийн үндэслэл, зураг төсөл батлагдсан үйл явцын талаарх танилцуулга	
6	Зам тээврийн яамны бодлого ба Нийслэлийн зам тээврийн мега төслүүдийн үйл ажиллагааны уялдаа холбоо (Туулын хурдны зам, Метро, Дүүжин тээвэр, Тойрог 1, 2-р зам, Трам, Тусгай замын автобус зэрэг)	Зам тээврийн яамны Авто замын бодлого зохицуулалтын газрын дарга Ч.Сугармаа

## **Оролцогчдын асуултад хариулах байдлаар тайлбар, мэдээлэл өгсөн албан тушаалтнууд:**

2026 оны 6 дугаар сарын 15-ны өдөр: Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны Хот байгуулалт, орон сууцны бодлого, зохицуулалтын газрын даргын АҮТОГ О.Одбаяр, “Эмээлт эко аж үйлдвэрийн парк” ХК-ийн гүйцэтгэх захирал Б.Мягмар, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч Б.Пүрэвдагва, Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын Нарийн бичгийн дарга бөгөөд Ажлын албаны дарга М.Халтар, АТГ-ын Хяналт шалгалт, дүн шинжилгээний хэлтсийн дарга Н.Даваатогтох, “Сэлбэ хорин минутын хот корпорац” ХХК-ийн гүйцэтгэх захирал У.Баатар, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын газрын дарга Ү.Ганболд, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Л.Эрдэнэбадрах, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Нийслэлийн Засаг даргын эдийн засгийн хөгжил, дэд бүтцийн асуудал хариуцсан нэгдүгээр орлогч Б.Мөнхбат, “Нэгдсэн төслийн удирдлагын газар” ОНӨТҮГ-ын захирал Э.Түвшинжаргал, Эрчим хүчний яамны салбарын хяналтын газрын дарга И.Лувсанцэрэн, Сангийн яамны Төсвийн бодлого төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, шинжээч Н.Энхбаяр, Нийслэлийн өмчит “Улаанбаатар хөрөнгө оруулалт, менежмент” ҮЦК ХХК-ийн гүйцэтгэх захирал Г.Гангамөрөн нар асуултад хариулав.

2026 оны 6 дугаар сарын 16-ны өдөр: Үндэсний аудитын газрын Бодлого, төлөвлөлт, инновацын газрын менежер Б.Батчимэг, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Байгаль орчны үнэлгээ, аудитын хэлтсийн дарга Б.Алтанзул, Зам, тээврийн яамны Авто замын бодлого, зохицуулалтын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ч.Сугармаа, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны Төрийн нарийн бичгийн дарга М.Баяраа, Хот байгуулалт, орон сууцны бодлого, зохицуулалтын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч О.Одбаяр, Төрийн худалдан авах ажиллагааны газрын дарга Ц.Батзул, Нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Нарийн бичгийн дарга бөгөөд Ажлын албаны дарга М.Халтар, Нийслэл дэх Төрийн аудитын газрын дарга Г.Нандинжаргал, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Л.Эрдэнэбадрах, Замын хөгжлийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.Одбаяр, Нийслэлийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга П.Хадбаатар, Хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Г.Гантулга, Зам тээврийн хөгжлийн төв ТӨҮГ-ийн Захиргааны дарга Б.Оюунболд, Бодлогын хэрэгжилт зураг төслийн магадлал, стандарт, норм нормативын хэлтсийн дарга Э.Балт, Барилгын хөгжлийн төв ТӨҮГ-ийн ерөнхий инженер З.Энх-Оргил, “Нэгдсэн төслийн удирдлагын газар” ОНӨТҮГ-ын дарга Э.Түвшинжаргал, “Сэлбэ хорин минутын хот корпорац” ХХК-ийн гүйцэтгэх захирал У.Баатар нар хариуцсан чиг үүрэг, чиглэлийн дагуу хариулт өгсөн.

## **ГУРАВ.СОНСГОЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА**

Сонсгол хоёр өдрийн турш дараах үе шаттай явагдсан:

1. Сонсгол даргалагч сонсголыг нээж, сонсголын зорилго, зохион байгуулалтын дэг, оролцогчдын эрх, үүрэг болон сонсголын хөтөлбөрийг танилцуулсан;
2. Төрийн байгууллага, холбогдох албан тушаалтан, шинжээчид танилцуулга, мэдээлэл, дүгнэлтээ танилцуулсан;
3. Иргэд, төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодын төлөөлөл санал, тайлбар, мэдээлэл өгсөн;

4. Сонсгол даргалагч оролцогчдоос урьдчилан бичгээр ирүүлсэн санал, хүсэлт, мэдээллийг танилцуулсан;
5. Улсын Их Хурлын гишүүд асуулт асууж, холбогдох байгууллага, албан тушаалтнуудаас хариулт, тайлбар авсан;
6. Улсын Их Хурлын гишүүд үг хэлж, байр сууриа илэрхийлсний дараа сонсгол даргалагч дүгнэлт хийж сонсголыг хаасан.

### **3.1.2026 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн сонсголын үйл ажиллагаа:**

Сонсголын эхний өдөр нийслэлийн төсвийн төлөвлөлт, зарцуулалт, хөрөнгө оруулалтын бодлого, нийслэлийн өмчит хуулийн этгээдийн үйл ажиллагаа, томоохон төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн талаарх үндсэн мэдээллийг хэлэлцэв.

Энэ хүрээнд холбогдох төрийн байгууллагууд болон нийслэлийн байгууллагуудаас мэдээлэл өгч, шинжээчдийн баг нийслэлийн төсвийн төлөвлөлт, төсвийн сахилга бат, нийслэлийн өмчит компаниудын засаглал, худалдан авах ажиллагаа, хөрөнгө оруулалтын төслүүдийн хэрэгжилттэй холбоотой урьдчилсан дүгнэлтүүдээ танилцуулсан.

Сонсголын үеэр Улсын Их Хурлын гишүүд нийслэлийн төсвийн орлого, зарлагын бүтэц, төсвийн алдагдал, үнэт цаасны санхүүжилт, нийслэлийн өмчит компаниудын удирдлага, төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүн, ашиг сонирхлын зөрчил, худалдан авах ажиллагааны ил тод байдал, хөрөнгө оруулалтын төсөл сонгон шалгаруулах үйл явцын талаар асуулт асууж, холбогдох байгууллагуудаас тайлбар авсан.

Мөн иргэд, төрийн бус байгууллага, судлаачдын төлөөлөл нийслэлийн төсвийн зарцуулалтын үр ашиг, нийтийн мэдээллийн ил тод байдал, иргэдийн оролцоо, төсөл хэрэгжүүлэх шийдвэр гаргалтын нээлттэй байдлын талаар санал, байр сууриа илэрхийлсэн.

### **3.2.2026 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн сонсголын үйл ажиллагаа:**

Сонсголын хоёр дахь өдөр Туулын хурдны зам, Сэлбэ дэд төв, нийслэлийн мега төслүүдийн төлөвлөлт, санхүүжилт, эдийн засгийн үр ашиг, худалдан авах ажиллагаа, төсөвт өртгийн тооцоо, магадлалын асуудал болон төсөл хэрэгжилтийн эрсдэлийн талаар төвлөрч хэлэлцэв.

Шинжээчдийн баг төслүүдийн техник, эдийн засгийн үндэслэл, төсөвт өртөг, худалдан авах ажиллагаа, хөрөнгө оруулалтын үр ашиг, эрсдэлийн үнэлгээтэй холбоотой дүгнэлтээ танилцуулж, Үндэсний аудитын газар аудитын урьдчилсан дүгнэлт, илэрсэн асуудлын талаар мэдээлэл өгсөн.

Хэлэлцүүлгийн үеэр Улсын Их Хурлын гишүүд Туулын хурдны зам төслийн төсөвт өртгийн өөрчлөлт, магадлалын байгууллагуудын дүгнэлтийн зөрүү, худалдан авах ажиллагааны хууль тогтоомжийн хэрэгжилт, Сэлбэ дэд төв төслийн газар чөлөөлөлт, орон сууцны нийлүүлэлт, санхүүжилтийн бүтэц, бондын эргэн төлөлтийн асуудлаар асуулт асууж, холбогдох байгууллагуудаас хариулт авсан.

Мөн нийслэлийн төсвийн бодлого, төвлөрөл сааруулах бодлого, орон нутгийн төсвийн эрх мэдэл, нийслэл болон улсын төсвийн чиг үүргийн зааг ялгаа, төсвийн

реформын шаардлагын талаар Улсын Их Хурлын гишүүд өргөн хүрээний хэлэлцүүлэг өрнүүлэв.

Сонсголын төгсгөлд Улсын Их Хурлын гишүүд үг хэлж, сонсголын үр дүн, цаашид авах арга хэмжээ, хууль эрх зүйн орчны шинэчлэл, төсвийн хяналтын тогтолцоог боловсронгуй болгох асуудлаар санал, байр сууриа илэрхийлсэн бөгөөд сонсгол даргалагч сонсголын үр дүнг нэгтгэн дүгнэж, холбогдох санал, зөвлөмжийг боловсруулан Төсвийн байнгын хороогоор хэлэлцүүлэхээр болсныг мэдэгдэн сонсголыг хаасан.

## **ДӨРӨВ.ТӨРИЙН БАЙГУУЛЛАГА, АЛБАН ТУШААЛТНЫ ХИЙСЭН ИЛТГЭЛ, МЭДЭЭЛЛҮҮД БОЛОН ШИНЖЭЭЧИЙН ДҮГНЭЛТ**

### **4.1.Улс ба нийслэлийн төсвийн уялдаа**

Сангийн сайд З.Мэндсайхан улсын болон нийслэлийн төсвийн харилцаа, төсвийн эрх зүйн орчин, нийслэлийн төсвийн орлого, зарлага, төсвийн алдагдал, үнэт цаасны санхүүжилт болон цаашид анхаарах шаардлагатай асуудлын талаар танилцуулга хийв.

Танилцуулгад дурдсанаар улсын төсөв болон нийслэлийн төсөв хоорондын харилцаа нь санхүүгийн дэмжлэг, төвлөрүүлэх орлого, аж ахуйн нэгжийн орлогын албан татварын хуваарилалт, орон нутгийн хөгжлийн сангийн шилжүүлэг, дамжуулан зээл, хөрөнгө оруулалт гэсэн үндсэн таван чиглэлээр хэрэгжиж байна. Гэвч улсын болон орон нутгийн төсвөөс санхүүжүүлэх чиг үүргийн зааг тодорхой бус хэвээр байгаа нь сургууль, цэцэрлэг, авто зам, нийтийн эзэмшлийн талбай зэрэг ижил төрлийн хөрөнгө оруулалтыг улсын болон нийслэлийн төсвөөс давхар санхүүжүүлэх нөхцөл үүсгэж байгааг онцлон тэмдэглэв.

Тэрээр 2021 онд Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хууль шинэчлэн батлагдсанаар нийслэлийн төсвийн орлого төвлөрүүлэх тогтолцоонд томоохон өөрчлөлт орсныг дурдав. Тухайлбал, аж ахуйн нэгжийн орлогын албан татварын 40 хувийг нийслэлд үлдээх болсон нь нийслэлийн төсвийн орлогын баазыг эрс нэмэгдүүлжээ. Үүний үр дүнд нийслэлийн төсвийн орлого 2025 оны гүйцэтгэлээр 3.8 их наяд төгрөгт хүрч, өмнөх оноос 24 хувиар өссөн байна. Нийслэлийн орлогын бүтцийн 52 хувийг хувь хүний орлогын албан татвар, 21 хувийг аж ахуйн нэгжийн орлогын албан татвар бүрдүүлж байгаа нь нийслэлийн эдийн засаг хөдөлмөр эрхлэлт, бизнесийн үйл ажиллагаанд өндөр төвлөрч байгааг харуулж байгааг тэмдэглэв.

Нийслэлийн төсвийн зарлага мөн адил эрчимтэй өссөн бөгөөд 2022 онд 1.4 их наяд төгрөг байсан нийт зарлага 2026 онд НИТХ-аар баталсан дүнгээр 7,8 их наяд төгрөгт хүрсэн байна. Сангийн сайдын тайлбарласнаар нийслэлийн эрх зүйн байдлын тухай хуулиар нийслэлд өргөн хүрээний чиг үүрэг, санхүүгийн эрх мэдэл шилжүүлсэн нь орлогын өсөлттэй зэрэгцэн зарлагын огцом тэлэлтийг бий болгосон байна.

Танилцуулгын үеэр нийслэлийн төсвийн алдагдлын асуудалд онцгойлон анхаарав. 2026 оны төсвийн төлөвлөгөөгөөр нийслэлийн төсвийн алдагдал 2,4 их наяд төгрөгт хүрч байгаа нь улсын нэгдсэн төсвийн батлагдсан алдагдал болох

ойролцоогоор 1,0 их наяд төгрөгөөс 1,4 их наяд төгрөгөөр өндөр үзүүлэлт болж байгааг мэдээлэв. Өөрөөр хэлбэл, нийслэлийн төсвийн алдагдал дангаараа нэгдсэн төсвийн алдагдлын 232.8 хувьтай тэнцэх хэмжээнд хүрч байгаа нь төсвийн тогтвортой байдалд эрсдэл учруулж болзошгүйг онцолсон.

Мөн нийслэлийн төсвийн алдагдал нэгдсэн төсвийн алдагдалд эзлэх хувь 2024 онд 29.5 хувь байсан бол 2025 онд 68.1 хувь болж өссөн бөгөөд 2026 онд цаашид нэмэгдэх төлөвтэй байгааг дурдав. Сангийн яамны зүгээс энэхүү нөхцөл байдал нь Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан шаардлагыг хангахад хүндрэл учруулж, улсын нэгдсэн төсвийн сахилга бат, макро эдийн засгийн тогтвортой байдалд сөргөөр нөлөөлөх эрсдэлтэй гэж үзэж байгаагаа илэрхийлсэн.

Сангийн сайд нийслэлийн төсвийн алдагдал нэмэгдэхэд нөлөөлж буй гол хүчин зүйлсийн нэг нь үнэт цаасны санхүүжилт болохыг онцлон тэмдэглэв. Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хууль болон холбогдох Засгийн газрын тогтоолуудын хүрээнд нийслэлээс томоохон төсөл, хөтөлбөрүүдийг санхүүжүүлэх зорилгоор дотоод, гадаад зах зээлд үнэт цаас гаргаж эхэлсэн байна.

Танилцуулгад дурдсанаар 2024-2026 онд Засгийн газрын 201, 264, 265 дугаар тогтоол болон холбогдох шийдвэрүүдийн дагуу нийт 2.9 их наяд төгрөг хүртэлх үнэт цаас гаргах зөвшөөрөл олгогдсоноос сонсгол болох үеийн байдлаар 2.7 их наяд төгрөгийн үнэт цаас гаргасан байна. Үүнд Бөөрөлжүүтийн дулааны цахилгаан станц, батарей хуримтлуурын төсөл, Сэлбэ дэд төвд түшиглэсэн орон сууцжуулах төсөл зэрэг томоохон бүтээн байгуулалтын санхүүжилт хамрагдаж байгааг танилцуулсан.

Тэрээр нийслэлийн гаргасан үнэт цааснууд нь өрийн удирдлагын тогтолцооны хүрээнд Засгийн газрын өрийн бүртгэлд тусгагдаж байгаа тул эргэн төлөлтийн эрсдэл үүссэн нөхцөлд улсын төсөвт шууд ачаалал болох эрсдэлтэйг анхааруулсан. Түүнчлэн УИХ-аас баталсан төсвийн хүрээний үзүүлэлт болон НИТХ-аас баталсан төсвийн хэмжээнд ихээхэн зөрүү үүссэнийг дурдсан. Тухайлбал 2026 онд УИХ-аас нийслэлийн орлогыг 3,4 их наяд төгрөг, зарлагыг 2,7 их наяд төгрөгөөр тооцсон бол НИТХ орлогыг 7,6 их наяд төгрөг, зарлагыг 7,8 их наяд төгрөгөөр баталсан нь төсвийн бодлого, хяналтын тогтолцоонд анхаарал хандуулах шаардлагатайг харуулж байна гэж үзжээ.

Олон улсын туршлагын талаар танилцуулахдаа төв Засгийн газар болон орон нутгийн чиг үүргийг хууль тогтоомжоор маш тодорхой заагласан байдаг бөгөөд үндэсний хэмжээний бодлого, батлан хамгаалах, гадаад харилцаа, эрчим хүч, төмөр зам зэрэг стратегийн чиг үүргийг төв Засгийн газар хэрэгжүүлдэг бол хот төлөвлөлт, нийтийн тээвэр, хотын авто зам, хог хаягдлын менежмент, нийтийн үйлчилгээ зэрэг асуудлыг орон нутгийн түвшинд хариуцдаг жишгийг дурдав.

Манай улсын хувьд чиг үүргийн хуваарилалт тодорхой бус байгаагаас улсын болон нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтын давхардал, төсвийн хариуцлагын асуудал үүсч байгааг тэмдэглэв.

Иймд Сангийн яамнаас нийслэлийн төсвийн алдагдалд тавих хяналтыг боловсронгуй болгох, Төсвийн тухай хууль дахь орон нутгийн төсвийн алдагдалгүй байх зарчим болон өмнөх оны үлдэгдлийг зарцуулах зохицуулалтын зөрчлийг арилгах, нийслэлийн чиг үүргийг санхүүжилтийн эх үүсвэртэй нь уялдуулан тодорхой

болгох, аж ахуйн нэгжийн орлогын албан татварын хуваарилалтын үр нөлөөг дахин үнэлэх, улсын болон нийслэлийн төсвийн эрх хэмжээ, хариуцлагын заагийг хууль тогтоомжийн түвшинд тодорхой болгох шаардлагатай талаар санал, дүгнэлтийг танилцуулсан болно.

#### **4.2.Нийслэлийн төсөв**

Нийслэлийн Засаг даргын нэгдүгээр орлогч Б.Пүрэвдагва “Нийслэлийн 2024-2026 оны төсвийн орлого, зарлага, хөрөнгө оруулалт, үнэт цаасны санхүүжилт, өрийн удирдлага болон томоохон төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн талаар” танилцуулга хийв. Тэрээр нийслэлийн төсвийн орлого, зарлага сүүлийн жилүүдэд тогтвортой өсөж байгаа бөгөөд энэ нь нийслэлийн эдийн засгийн идэвхжил, татварын бааз суурийн өргөжилт, төсвийн шинэчлэлтэй холбоотой гэж тайлбарлав.

Танилцуулгад дурдсанаар Төсвийн тухай хуульд 2021 онд орсон нэмэлт, өөрчлөлтийн дагуу аж ахуйн нэгжийн орлогын албан татварын 40 хувийг нийслэлийн төсөвт төвлөрүүлэх болсон нь нийслэлийн төсвийн орлогын бүтцэд томоохон өөрчлөлт авчирсан байна. Нийслэлийн төсвийн нийт орлого 2024 онд 3,0 их наяд төгрөг байсан бол 2025 оны гүйцэтгэлээр 3,8 их наяд төгрөгт хүрч, өмнөх оноос 24 хувиар өссөн байна. 2026 онд нийт 5,4 их наяд төгрөгийн орлого төвлөрүүлэхээр төлөвлөсөн бөгөөд нийт орлогын 58 хувийг хувь хүний орлогын албан татвар, 29 хувийг аж ахуйн нэгжийн орлогын албан татвар бүрдүүлж байгаа нь орлогын 70 орчим хувь нь хөдөлмөр эрхлэлт, бизнесийн үйл ажиллагаанаас хамаарч байгааг харуулж байна.

2026 оны эхний таван сарын байдлаар нийслэлийн төсөвт 1.59 их наяд төгрөг төвлөрч, орлогын төлөвлөгөө 81.7 хувийн биелэлттэй гарсан байна. Нийслэлийн зүгээс татварын баазыг өргөжүүлэх, татвар төлөгчдийн бүртгэлийг сайжруулах, далд эдийн засгийг бууруулах чиглэлээр хэрэгжүүлсэн арга хэмжээ нь төсвийн орлогын өсөлтийг дэмжсэн гэж тайлбарлав.

Нийслэлийн төсвийн зарлагын тухайд 2024 онд 3,4 их наяд төгрөг байсан нийт зарлага 2025 оны гүйцэтгэлээр 4,5 их наяд төгрөгт хүрч, өмнөх оноос 32 орчим хувиар өссөн байна. Харин 2026 онд Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас 7,8 их наяд төгрөгийн зарлагатай төсөв баталсан бөгөөд нийт зарлагын 64.7 хувийг хөрөнгө оруулалтын зардал эзэлж байгаа нь нийслэлээс дэд бүтэц, нийтийн тээвэр, инженерийн байгууламж, боловсролын салбарын томоохон төслүүдийг эрчимтэй хэрэгжүүлэх бодлого баримталж байгааг илэрхийлж байна.

Урсгал зардлын бүтцэд хот тохижуулах үйл ажиллагаанд 495,2 тэрбум төгрөг, нийтийн тээврийн үйлчилгээ болон нөхөн олговорт 377,6 тэрбум төгрөг, төрийн албан хаагчдын цалин хөлс, нийгмийн даатгалын шимтгэлд 329,2 тэрбум төгрөг, байр ашиглалттай холбоотой тогтмол зардалд 161,8 тэрбум төгрөг, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд 79,7 тэрбум төгрөг, СОП-17 арга хэмжээнд 70,1 тэрбум төгрөг, агаарын бохирдлыг бууруулах арга хэмжээнд 52,3 тэрбум төгрөг тус тус төлөвлөсөн талаар мэдээлэв.

Хөрөнгө оруулалтын тухайд нийслэл, дүүргийн хэмжээнд 2026 онд нийт 5,1 их наяд төгрөгийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр баталсан бөгөөд эхний таван сарын байдлаар 629,8 тэрбум төгрөгийн санхүүжилт олгож,

төлөвлөгөөний гүйцэтгэл 97.8 хувьтай байна. Нийслэлийн хөрөнгө оруулалтын хэмжээ 2024 онд 1,4 их наяд төгрөг байсан бол 2025 онд 2,1 их наяд төгрөг болж өссөн бөгөөд 2026 онд 4,7 их наяд төгрөгт хүрэхээр төлөвлөгдсөн нь сүүлийн жилүүдэд хөрөнгө оруулалтын цар хүрээ эрс нэмэгдсэнийг харуулж байна.

2026 онд нийслэлийн төсвийн хөрөнгөөр авто зам, замын байгууламжийн шинэчлэл, засвар арчлалт, метро, трамвай, газар чөлөөлөлт, сургууль, цэцэрлэгийн хүртээмжийг нэмэгдүүлэх, он дамжин хэрэгжиж буй төслүүдийг дуусгах зэрэг томоохон арга хэмжээг санхүүжүүлэхээр төлөвлөсөн байна. Түүнчлэн Туулын хурдны замын төсөлд батлагдсан 800 тэрбум төгрөгөөс сонсгол болох үеийн байдлаар санхүүжилт олгоогүй бөгөөд холбогдох шалгалтын ажиллагааны үр дүнгээс хамааран уг асуудлыг дахин авч үзэх боломжтой гэж мэдэгдэв.

Нийслэлийн үнэт цаасны хөрөнгөөр Сэлбэ дэд төвийн орон сууцны иж бүрэн цогцолбор хороолол, Дулааны цахилгаан станц-5, Туул-1 коллектор, эрчим хүчний хуримтлуурын станц зэрэг төслүүдийг санхүүжүүлэхээр төлөвлөсөн байна.

Танилцуулгад дурдсанаар 2024-2026 онд Засгийн газрын 201, 264, 265 дугаар тогтоол болон 2026 оны 49 дүгээр тогтоолын хүрээнд нийт 2,7 их наяд төгрөгийн үнэт цаас гаргасан бөгөөд эдгээрийг 1-5 жилийн хугацаатай, 7.4-14.0 хувийн хүүтэйгээр үе шаттай арилжаалжээ. Нийслэлээс гаргасан үнэт цаасны үлдэгдэл сонсгол болох үеийн байдлаар 2,66 их наяд төгрөг байгаа бөгөөд нэг жилийн хугацаатай 100 тэрбум төгрөгийн үнэт цаасыг хугацаанд нь бүрэн төлж барагдуулсан нь өрийн эргэн төлөлтийн сахилга бат хангагдаж байгааг харуулж байна гэж тайлбарлав.

Танилцуулгын төгсгөлд нийслэлийн төсвийн орлого, хөрөнгө оруулалтын хэмжээ өмнөх жилүүдтэй харьцуулахад мэдэгдэхүйц өссөн бөгөөд уг боломжийг нийтийн тээврийн шинэчлэл, түгжрэлийг бууруулах, инженерийн дэд бүтцийг өргөтгөх, боловсролын хүртээмжийг нэмэгдүүлэх, орон сууцжуулах томоохон төслүүдийг хэрэгжүүлэхэд чиглүүлж байгааг онцлон тэмдэглэв. Мөн үнэт цаасны санхүүжилтээр хэрэгжиж буй төслүүдийг хугацаанд нь ашиглалтад оруулж, өрийн эргэн төлөлтийг төсвийн орлоготой уялдуулан хэрэгжүүлэх бодлого баримталж байгааг мэдэгдсэн болно.

#### **4.3.Нийслэлийн өмчийн оролцоотой хуулийн этгээдүүдийн хэрэгжүүлж буй төслүүдийн цар хүрээ, зарцуулалт, ирээдүйн хөрөнгө оруулалтын нэгдсэн дүн**

Нийслэлийн өмчийн харилцааны газрын дарга В.Оюумаа нийслэлийн өмчит болон өмчийн оролцоотой хуулийн этгээдүүдийн үйл ажиллагааны үр дүн, санхүүгийн үзүүлэлт, томоохон төсөл, хөтөлбөрүүдийн хэрэгжилтийн талаар танилцуулга хийв.

Нийслэлийн хэмжээнд 16 компани, 26 орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд нийт 40 гаруй хуулийн этгээд нийслэлийн өмчийн оролцоотойгоор ажиллаж байна.

Танилцуулгад дурдсанаар 2025 оны байдлаар компаниудаас 7 нь нийт 7,6 тэрбум төгрөгийн ашигтай, 9 нь 14 тэрбум төгрөгийн алдагдалтай ажилласан бол орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газруудаас 18 нь 18,3 тэрбум төгрөгийн ашигтай, 6 нь алдагдалтай ажилласан бөгөөд 4 үйлдвэрийн газар аудитын хязгаарлалттай дүгнэлт авсан байна.

Нийслэлийн өмчийн оролцоотой 16 компанийн нийт орлого 159,7 тэрбум төгрөг, нийт зардал 165,7 тэрбум төгрөгт хүрч, 6,4 тэрбум төгрөгийн алдагдалтай ажилласан байна. Мөн эдгээр байгууллагын нийт өр төлбөр 808,3 тэрбум төгрөгт хүрсэн нь санхүүгийн тогтвортой байдал, засаглалын үр ашигт анхаарах шаардлагатай байгааг харуулж байна.

Танилцуулгад нийслэлийн хэмжээнд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн 16 томоохон мега төслийн талаар дэлгэрэнгүй мэдээлэл өгсөн. Эдгээр төслийн нийт төсөвт өртөг 28,9 их наяд төгрөг бөгөөд 2026 оны эхний хагас жилийн байдлаар 1,4 их наяд төгрөгийн санхүүжилт хийгдэж, нийт хэрэгжилт 4.8 хувьтай байна. Санхүүжилтийн бүтцийг авч үзвэл нийт хөрөнгө оруулалтын 47.9 хувийг гадаад зээл, 23,4 хувийг төр-хувийн хэвшлийн түншлэл, 17.5 хувийг нийслэлийн төсөв, 9.2 хувийг нийслэлийн үнэт цаасны эх үүсвэрээр санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Мега төслүүдээс Улаанбаатар метро төслийн ТЭЗҮ бүрэн боловсруулагдаж, байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ батлагдсан бөгөөд ерөнхий гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах хоёрдугаар шатны ажиллагаа үргэлжилж байгаа талаар мэдээлэв. Төслийн нийт төсөвт өртөг 2,4 тэрбум ам.доллар бөгөөд 2024-2030 онд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

Трамвайны 1, 2 дугаар шугамын төслүүдийн ТЭЗҮ бүрэн боловсруулагдсан боловч газар чөлөөлөлт, сонгон шалгаруулалтын шатанд явж байна. Тухайлбал, 2 дугаар шугамын тендер шалгаруулалттай холбоотой асуудлаар Монополын эсрэг газарт гомдол гарсан тул сонгон шалгаруулалтын ажиллагаа түр хойшлогдсон талаар дурдав.

Хот байгуулалтын чиглэлийн төслүүдээс Сэлбэ хот орон сууцжуулах төслийн газар чөлөөлөлт 95 хувиас дээш хангагдаж, барилга угсралтын ажил 32 хувийн гүйцэтгэлтэй хэрэгжиж байгаа бол Дамбадаржаа дэд төвийн төсөл 71 хувь, Баянхошуу дэд төв 45.6 хувь, Толгойт дэд төв 39 хувийн гүйцэтгэлтэй байгаа талаар мэдээлэв.

Тээврийн салбарын төслүүдээс агаарын дүүжин тээврийн төслийн хэрэгжилт хамгийн өндөр буюу 74.8 хувьд хүрсэн бөгөөд газар чөлөөлөлт бүрэн хийгдэж, барилга угсралтын ажил 72 хувийн явцтай байгааг онцолсон. Харин тусгай замын автобус (BRT), Туул усан цогцолбор зэрэг төслүүд ТЭЗҮ болон бэлтгэл ажлын шатанд байгаа бөгөөд нийт хэрэгжилт харьцангуй бага түвшинд байна.

Туулын хурдны замын төслийн ТЭЗҮ бүрэн боловсруулагдсан, 112 нэгжээс 51 нэгжийн газар чөлөөлөлт хийгдсэн, төслийн хэрэгжилт 13.15 хувьд хүрсэн боловч үндсэн барилга угсралтын ажил түр зогссон байгааг танилцуулгад дурдсан.

Мөн Дулааны V цахилгаан станц, Эмээлт эко аж үйлдвэрийн парк, лаг шатаах үйлдвэр, хог шатааж эрчим хүч үйлдвэрлэх үйлдвэр зэрэг эрчим хүч, дэд бүтцийн төслүүдийг төр-хувийн хэвшлийн түншлэл болон гадаадын зээлийн эх үүсвэрээр хэрэгжүүлэхээр төлөвлөж байгаа талаар мэдээлэл өгсөн.

Танилцуулгын төгсгөлд төслүүдийн хэрэгжилтийн явц, санхүүжилтийн бүтэц, техник, эдийн засгийн үндэслэлийн боловсруулалт, газар чөлөөлөлтийн байдал

болон цаашдын хэрэгжилтийн төлөвлөгөөний талаар холбогдох төсөл хэрэгжүүлэгч байгууллагууд нэмэлт тайлбар өгөхөд бэлэн байгааг илэрхийлэв.

#### 4.4.Шинжээчдийн дүгнэлт

1) Нийслэлийн төсвийн төлөвлөлт, төсвийн сахилга бат, хөрөнгө оруулалтын төсөл, хөтөлбөрийн хэрэгжилт, мега төслүүдийн санхүүжилт, нийслэлийн өмчит хуулийн этгээдийн засаглал, эдийн засаг, санхүүгийн үнэлгээний асуудлаар дүн шинжилгээ хийж, холбогдох дүгнэлтийг шинжээч Д.Хосжаргал, Б.Мөнхбат нар сонсголд танилцуулав.

Шинжээчдийн дүгнэлтээр нийслэлийн төсөв сүүлийн жилүүдэд эрчимтэй өссөн хэдий ч төсвийн төлөвлөлт, төсвийн сахилга баттай холбоотой зарим асуудал байгааг онцолжээ. Тухайлбал, нийслэл 2024 онд төсвөө дөрвөн удаа, 2025 онд таван удаа тодотгож, тодотгол бүрээр төсвийн алдагдлыг нэмэгдүүлсэн нь Төсвийн тухай хуульд заасан төсвийг алдагдалгүй батлах зарчимтай нийцэхгүй байна гэж үзсэн байна.

Мөн нийслэлээс хэрэгжүүлэхээр төлөвлөсөн 16 мега төслийн нийт төсөвт өртөг 28,9 их наяд төгрөгт хүрч байгаа бөгөөд сонсгол болох үеийн байдлаар санхүүжилтийн гүйцэтгэл ердөө 1,4 их наяд төгрөг буюу 5 хувьтай байгааг танилцуулсан. Эдгээр төслийн нийт төсөвт өртгийн 66 хувь буюу 19,1 их наяд төгрөгийг гадаадын зээл болон төр-хувийн хэвшлийн түншлэлийн эх үүсвэрээр санхүүжүүлэхээр төлөвлөсөн боловч уг санхүүжилтийн эх үүсвэрүүд бүрэн баталгаажаагүй байгаа нь төсөл хэрэгжих хугацаа, санхүүжилтийн тогтвортой байдалд эрсдэл үүсгэж болзошгүй гэж дүгнэжээ.

Шинжээчид томоохон төсөл, арга хэмжээнүүдийн бэлтгэл хангалт хангалтгүй байгааг мөн онцолсон. Зарим төсөл ТЭЗҮ, зураг төсөл, газрын асуудал, магадлалын дүгнэлт, олон нийтийн оролцоог хангах ажиллагаа бүрэн дуусаагүй байхад төсөвт тусгагдсан бөгөөд зарим төсөл 5-12 жил дамжин хэрэгжиж байгаа нь Төсвийн тухай хуульд заасан хөрөнгө оруулалтын төслийг гурван жилийн хугацаанд хэрэгжүүлэх зарчимтай нийцэхгүй байгааг дурдсан. Үүний улмаас зарим төслийн төсөвт өртөг анхны тооцооноос дунджаар 2.8 дахин өссөн талаар мэдээлжээ.

Нийслэлийн аудитын байгууллагын дүгнэлтэд үндэслэн захиалагчийн хяналтад байсан 34 төсөл, арга хэмжээний зураг төсөв, байршил, газар чөлөөлөлтийн асуудал бүрэн шийдвэрлэгдээгүй байхад нийт 380 тэрбум төгрөгийн санхүүжилт олгосон бөгөөд үүний 321 тэрбум төгрөг нь урьдчилгаа төлбөр байсан талаар танилцуулсан. Шинжээчдийн үзэж байгаагаар хөрөнгө оруулалтын төслийн бэлтгэл хангалт бүрдээгүй үед төсвийн хөрөнгө санхүүжүүлж байгаа нь төсвийн үр ашиг, санхүүгийн хяналтын тогтолцоонд сөргөөр нөлөөлөх эрсдэлтэй байна.

Түүнчлэн нийслэлийн өмчит болон өмчийн оролцоотой 40 гаруй хуулийн этгээдийн засаглалын асуудлыг хөндөн авч үзжээ. Судалгаагаар НИТХ-ын 45 төлөөлөгчөөс 43 нь нийслэлийн өмчит компаниудын төлөөлөн удирдах зөвлөл болон удирдах түвшний албан тушаалд нийт 104 суудал эзэлж байгаа бөгөөд эдгээрийн 65 суудал буюу 62.5 хувь нь 19 төлөөлөгчид төвлөрсөн байна. Энэхүү нөхцөл байдал нь төлөөллийн байгууллагын хяналтын чиг үүрэг болон өмчит компанийн удирдлагын

чиг үүрэг давхцах, ашиг сонирхлын зөрчил үүсэх эрсдэлийг нэмэгдүүлж байгааг шинжээчид онцлон тэмдэглэв.

Мөн эдийн засаг, санхүүгийн үр ашгийн үнэлгээний чанартай холбоотой асуудлыг дурдаж, нийслэлд хэрэгжүүлж буй томоохон төслүүдийн эдийн засгийн шинжилгээ, эрсдэлийн үнэлгээнд нэгдсэн аргачлал, стандарт хангалтгүй байгааг тэмдэглэсэн. Тухайлбал, Туулын хурдны замын төслийн эдийн засгийн үр ашгийн тооцоонд цэвэр өнөөгийн үнэ цэнийг төсөвт өртгийн 38 хувьтай тэнцэх хэмжээний ашигтай гэж тооцсон нь ашигласан таамаглал, өгөгдлийн үндэслэл, эрсдэлийн үнэлгээний бодитой байдалд эргэлзээ төрүүлж байгааг дурджээ.

Шинжээчдийн дүгнэлтээс үзэхэд нийслэлийн төсөв, хөрөнгө оруулалтын бодлого нь хотын хөгжлийн тулгамдсан асуудлыг шийдвэрлэх зорилготой боловч төсвийн сахилга бат, хөрөнгө оруулалтын төслийн бэлтгэл хангалт, санхүүжилтийн баталгаажуулалт, өмчит хуулийн этгээдийн засаглал, эдийн засгийн үр ашгийн үнэлгээний тогтолцоог боловсронгуй болгох шаардлагатай байна гэж үзсэн болно.

2) Нийслэлийн 2024-2026 оны төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөлт, батлалт, хэрэгжилт, орон нутгийн өмчит хуулийн этгээдийн үйл ажиллагаа, олон нийтийн оролцоо болон холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийн асуудлаар хийсэн судалгаа, дүн шинжилгээний үр дүнг шинжээч Б.Энхчимэг танилцуулав. Судалгааг 2024, 2025 оны аудитын тайлан, нийслэлийн төсөв, хөгжлийн бодлогын баримт бичиг, хууль тогтоомж болон төсөл, хөтөлбөрүүдийн хэрэгжилтийн мэдээлэлд тулгуурлан боловсруулжээ.

Шинжээчийн дүгнэлтээр нийслэлд хэрэгжиж буй томоохон төсөл, арга хэмжээний хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигтэй уялдах шаардлага бүрэн хангагдаагүй байна. Нийслэлийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт анх 14 төсөл тусгагдсан бөгөөд дараа нь нэмэлт өөрчлөлтөөр 16 төсөл болгон өргөжүүлсэн байна. Гэвч эдгээр төслөөс зөвхөн агаарын дүүжин тээврийн төсөл нь 2021-2025 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөрт тусгагдсан байжээ. Мөн төслүүдийг үндэслэсэн 2040 оны хөгжлийн ерөнхий төлөвлөгөө Улсын Их Хурлаар батлагдаагүй хэвээр байгаа бөгөөд төслүүдийг батлагдаагүй бодлогын баримт бичигт тулгуурлан төлөвлөсөн нөхцөл байдал тогтоогдсон байна.

Төсвийн тухай хуульд зааснаар хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ нь техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөв, газрын зөвшөөрөл, магадлалын дүгнэлт, урсгал зардлын тооцоолол болон олон нийтийн хэлэлцүүлгээр баталгаажсан байх шаардлагатай. Гэвч аудитын дүгнэлтээр 2024 онд шинээр батлагдсан 113 багц төсөл, арга хэмжээний 24-д нь зардлын тооцоолол хийгдээгүй, 13 нь хөгжлийн бодлоготой нийцээгүй, 12 нь жилийн хөгжлийн төлөвлөгөөтэй уялдаагүй байжээ. Мөн 93 барилга байгууламжийн төслийн 51 нь зураг төсөвгүйгээр батлагдсан байна.

Түүнчлэн газрын асуудал шийдвэрлэгдээгүй, дулааны эх үүсвэр тодорхойгүй, зураг төсөвгүй төслүүд төсөвт тусгагдсан бөгөөд үүний улмаас зарим төслийн хэрэгжилт удааширч, төсөвт өртөг нэмэгдсэн байна. Жишээлбэл, 129 дүгээр цэцэрлэгийн өргөтгөлийн төсөл зураг төсөвгүй батлагдсанаас төсөвт өртөг нэмэгдсэн

бол “Улаанбаатар театр”-ын их засварын ажил магадлалын дүгнэлт, техникийн тодорхойлолтуугийг төсөвт тусгагдсан ч тайлант хугацаанд хэрэгжээгүй байна.

2025 оны төсөвт мөн адил ижил төрлийн зөрчлүүд үргэлжилсэн бөгөөд батлагдсан 118 төсөл, арга хэмжээний 9 нь таван жилийн үндсэн чиглэлтэй, 11 нь Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөртэй, 23 нь тухайн жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөтэй уялдаагүй байсан байна. Мөн 60 төсөл зураг төсөвгүй, 14 төсөл магадлалын дүгнэлтийн хугацаа дууссан, олон төсөл газрын зөвшөөрөлгүйгээр батлагдсан нь тогтоогджээ.

Шинжээчийн танилцуулгад зураг төсөв, магадлалын дүгнэлт, газрын асуудал бүрэн шийдвэрлэгдээгүй 75 төсөл, арга хэмжээг эхлүүлж, нийт 380.3 тэрбум төгрөгийн санхүүжилт олгосон бөгөөд үүний 84.5 хувь нь урьдчилгаа төлбөр хэлбэрээр санхүүжүүлэгдсэн талаар дурдсан.

Шинжээч Захиргааны ерөнхий хуульд заасан төлөвлөлтийн сонсголын хэрэгжилтийг тусгайлан авч үзсэн. Сонсголын бэлтгэл ажлын хүрээнд нийслэлээс 6 төсөлтэй холбоотой олон нийтийн оролцооны баримт материалыг ирүүлсэн боловч эдгээр нь ихэвчлэн хэрэгцээний судалгаа, байгаль орчны нөлөөллийн үнэлгээний хэлэлцүүлэг байсан бөгөөд хуульд заасан төлөвлөлтийн сонсголын шаардлагыг бүрэн хангаагүй гэж дүгнэжээ. Тухайлбал, Туулын хурдны замын төслийн гэрээ 2025 оны 8 дугаар сард байгуулагдсан байхад байгаль орчны үнэлгээтэй холбоотой хэлэлцүүлгийг дараа нь буюу 2025 оны 11 дүгээр сараас 2026 оны 2 дугаар сарын хооронд зохион байгуулсан нь шийдвэр гарсны дараа олон нийтийн оролцоог хангах оролдлого болсон гэж үзсэн байна. Мөн иргэдэд зөвхөн хэрэгцээ, байгаль орчны асуудлаар мэдээлэл өгсөн бөгөөд ТЭЗҮ, зураг төсөл, санхүүжилтийн тооцоо зэрэг шийдвэр гаргахад чухал мэдээллийг бүрэн хүргээгүй гэж үзжээ.

Шинжээчийн судалгаагаар нийслэлийн өмчит болон өмчийн оролцоотой аж ахуйн нэгжийн тоо сүүлийн жилүүдэд эрчимтэй өссөн байна. Улсын бүртгэлийн мэдээллээр нийт 80 байгууллага бүртгэлтэй байгаагаас 75 нь үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд 2024-2026 онд л гэхэд 24 байгууллага шинээр байгуулагджээ. Энэхүү өсөлт нь захиргааны зардал нэмэгдэх, чиг үүргийн давхардал бий болох, хариуцлага сарних эрсдэлийг нэмэгдүүлж байгааг онцолсон.

Тээвэр, орон сууц, хот байгуулалт, эрчим хүч, хог хаягдлын чиглэлээр ижил төстэй чиг үүрэг бүхий олон байгууллага байгуулагдсан нь төсвийн үр ашиг буурах, удирдлагын давхардал бий болгох эрсдэлтэй гэж үзжээ. Мөн хүнсний хангамж, программ хангамж, хөрөнгө оруулалтын менежмент, захиалагчийн хяналт зэрэг хувийн хэвшлээр хэрэгжүүлэх боломжтой чиглэлд орон нутгийн өмчит байгууллага байгуулсан нь зах зээл дэх төрийн оролцоог нэмэгдүүлж, өрсөлдөөнийг хязгаарлах эрсдэлтэй талаар дурдсан байна.

Шинжээчийн дүгнэлтээр нийслэлийн өмчит байгууллагуудын засаглалтай холбоотой ашиг сонирхлын зөрчлийн эрсдэл өндөр түвшинд байна. Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 16 төлөөлөгч орон нутгийн өмчит үйлдвэрийн газрын удирдлагад ажиллаж байгаа бол 35 төлөөлөгч өмчит компаниудын Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнд ажиллаж байна. Нөгөө талаас эдгээр төлөөлөгчид тухайн байгууллагуудын төсөв, хөрөнгө оруулалт, санхүүжилтийг хэлэлцэн батлах

шийдвэр гаргах үйл ажиллагаанд оролцож байгаа нь ашиг сонирхлын зөрчил үүсэх нөхцөлийг бүрдүүлж байна гэж үзжээ.

Мөн нийслэлээс төсөв батлах үеэр ашиг сонирхлын зөрчилтэй холбоотой мэдэгдэл гаргасан эсэх, тухайн асуудлаар санал хураалтад оролцоогүй эсэх талаар нотлох мэдээлэл ирүүлээгүй тул холбогдох хууль тогтоомжийн зөрчил гарсан байж болзошгүй гэсэн дүгнэлтэд хүрсэн байна.

Шинжээчийн дүгнэлтээр нийслэлийн томоохон төсөл, арга хэмжээний төлөвлөлт нь хөгжлийн бодлого, төсөв, төлөвлөлтийн уялдаа хангалтгүй, ТЭЗҮ, зураг төсөв, газрын зөвшөөрөл, техникийн тодорхойлолт, урсгал зардлын тооцоолол бүрэн хийгдээгүй төслүүдийг төсөвт тусган баталж байгаа нь төсөвт өртөг нэмэгдэх, хэрэгжилт удаашрах, хөрөнгө оруулалтын үр ашиг буурах эрсдэлийг бий болгож байна гэж үзсэн. Мөн олон нийтийн оролцоо бодитой хангагдаагүй, орон нутгийн өмчит байгууллагуудын тоо огцом өсч, чиг үүргийн давхардал нэмэгдсэн, ашиг сонирхлын зөрчлийн эрсдэл өндөр байгаа бөгөөд өмчит компаниудын засаглал, хяналтын тогтолцоо хангалтгүй байна гэсэн нэгдсэн дүгнэлт гаргасан байна.

Цаашид төсөв, төлөвлөлтийн уялдааг сайжруулах, төслийн бэлтгэл шаардлагыг бүрэн хангах, өмчит байгууллагуудын хэрэгцээ, чиг үүргийг дахин үнэлэх, ашиг сонирхлын зөрчлийг ил тод болгох, аудитын зөвлөмжийн хэрэгжилтэд хариуцлага тооцох шаардлагатай гэж үзжээ.

3) Нийслэлээс хэрэгжүүлж буй 16 мега төслийн төсвийн гүйцэтгэл, эдийн засаг, санхүүгийн шинжилгээний чанар, санхүүжилтийн эх үүсвэрийн бодит байдлыг судалж шинжээч В.Данаасүрэн дүгнэлт гаргасан. Түүний танилцуулснаар 16 төслийн нийт төсөвт өртөг 28.9 их наяд төгрөг бөгөөд энэ нь 2025 оны улсын төсвийн 93 хувьтай тэнцэх хэмжээний дүн юм. Нийт төсөвт өртгийн 70 хувийг метро, 1 ба 2 дугаар тойрог зам, Сэлбэ хот, Дулааны V цахилгаан станц, Туулын хурдны зам зэрэг зургаан том төсөл бүрдүүлж байна.

Төслүүдийн хэрэгжилтийн явц хангалтгүй байгааг онцолж, нийт төсөвт өртгийн ердөө 5 хувь буюу 1.4 их наяд төгрөгийг зарцуулсан байхад 2026 онд нийт төсөвт өртгийн 22.3 хувь буюу 6.4 их наяд төгрөгийг зарцуулахаар төлөвлөсөн нь хэрэгжилтийн эрсдэлийг нэмэгдүүлж байгааг дурдсан. Тухайлбал метро, трамвай, тойрог зам зэрэг томоохон төслүүдийн гүйцэтгэл маш бага түвшинд байгаа нь төслийн бэлтгэл хангалтгүй, санхүүжилтийн асуудал бүрэн шийдэгдээгүйтэй холбоотой гэж үзжээ.

Санхүүжилтийн бүтцийн хувьд нийт хөрөнгийн 54 хувь буюу 15.5 их наяд төгрөгийг гадаадын зээл, бондоор санхүүжүүлэхээр төлөвлөсөн нь төсөв болон өрийн удирдлагад өндөр эрсдэл дагуулж болзошгүй гэж дүгнэсэн. Хэрэв төслүүд хугацаандаа хэрэгжихгүй бол төсөвт өртөг нэмэгдэх, зээлийн ашиглалт муудах, өрийн дарамт өсөх эрсдэлтэйг анхааруулсан байна.

Эдийн засаг, санхүүгийн шинжилгээний хувьд төслүүдэд нэгдсэн аргачлал ашиглаагүй, өөр өөр байгууллагын боловсруулсан ТЭЗҮ-д тулгуурласан нь төслүүдийг хооронд нь харьцуулах боломжийг хязгаарлаж байгааг тэмдэглэсэн. Сэлбэ хотын төслийн эдийн засгийн өгөөжийн тооцоолол огт хийгдээгүй, харин Туулын хурдны замын төслийн өгөөжийн тооцоолол хэт өөдрөг төсөөлөлд тулгуурласан гэж үзжээ. Тухайлбал байгаль орчин, нийгмийн сөрөг нөлөөллийг

зардалд тусгаагүй атлаа төслийн цэвэр өнөөгийн үнэ цэнийг төсөвт өртгийн 38 хувьтай тэнцэх хэмжээнд ашигтай гэж тооцсон нь бодит байдалтай нийцэх эсэхэд эргэлзээтэй гэж дүгнэсэн байна.

Мөн метро, трамвай, BRT, дүүжин тээвэр, Туулын хурдны зам зэрэг түгжрэлийг бууруулах зорилготой ижил чиглэлийн төслүүдийн нийлмэл үр нөлөөг тооцоогүй, зорчигч урсгалын давхардал болон эдийн засгийн өгөөж буурах эрсдэлийг үнэлээгүй байгааг онцолсон. Иймд төслүүдийн ТЭЗҮ-д тавигдах шаардлагыг сайжруулах, эдийн засаг, санхүүгийн шинжилгээний нэгдсэн стандарт мөрдүүлэх, төсөв болон өрийн ачааллын үнэлгээг заавал хийх, төслүүдийг ач холбогдол, үр өгөөжөөр нь эрэмбэлэн сонгох, төсөвлөлт болон зарцуулалтын мэдээллийг олон нийтэд ил тод болгох шаардлагатай гэж зөвлөсөн.

Эцэст нь, санхүүжилтийн эх үүсвэр бүрэн баталгаажаагүй, эдийн засгийн тооцоолол хангалтгүй, төслүүдийн уялдаа холбоо болон нийлмэл нөлөөлөл дутуу үнэлэгдсэн нөхцөлд мега төслүүдийг зэрэг хэрэгжүүлэх нь төсвийн үр ашиг, өрийн тогтвортой байдалд сөрөг нөлөө үзүүлэх эрсдэлтэй гэж дүгнэсэн.

#### **4.5. Авлигатай тэмцэх газрын мэдээлэл**

Авлигатай тэмцэх газрын дэд дарга Г.Азжаргал нийслэлийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнүүдтэй холбоотой мөрдөн шалгах ажиллагааны явцын талаар мэдээлэл өгсөн. Түүний мэдээлснээр Улсын ерөнхий прокурорын газрын шийдвэрээр 2026 оны 5 дугаар сарын 19-ний өдөр байгуулагдсан хамтарсан ажлын хэсэг нийслэлийн томоохон төсөл, арга хэмжээнүүдэд хяналт шалгалт хийж байна. Шалгалтад Туулын хурдны замын 2.3 их наяд төгрөгийн төсөвт өртөгтэй төсөл, Шинэ тойрог авто замын ТЭЗҮ, зураг төсөл боловсруулах ажил, Сэлбэ дэд төвийн орон сууцны цогцолборын багц ажлууд зэрэг нийт 24 төсөл хамрагдсан байна. Үүнээс 13 төсөлд санхүүжилт олгогдож хэрэгжилт эхэлсэн бөгөөд 11 төсөлд санхүүжилт олгогдоогүй байжээ.

Мөрдөн шалгах ажиллагааны хүрээнд 30 төсөлтэй холбоотой 30 дансны нийт 2.6 их наяд төгрөгийн гүйлгээнд прокурорын зөвшөөрлөөр хязгаарлалт тогтоосон бөгөөд 8 хүнийг яллагдагчаар татаж, 3 хүнийг цагдан хорьсон талаар мэдээлсэн.

АТГ-ын Хяналт шалгалт, дүн шинжилгээний хэлтсийн дарга М.Даваатогтох нийслэлийн хэмжээнд ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг (ХАСУМ), хөрөнгө орлогын мэдүүлэг (ХОМ), ашиг сонирхлын зөрчилтэй холбоотой хяналт шалгалтын дүнг танилцуулсан.

2024 онд нийслэлийн хэмжээнд томилогдохоор нэр дэвшсэн 1,725 албан тушаалтны ХАСУМ-ийг хянаж, 80 албан тушаалтан 198 сая төгрөгөөс дээш хэмжээний хөрөнгө, орлогын өөрчлөлт мэдүүлсэн байна. 2025 онд 821 албан тушаалтны мэдүүлгийг шалгаснаас 693-ыг зөрчилгүй, 98-д нь ашиг сонирхлын зөрчил үүсэх эрсдэлийн талаар анхааруулж, 6 албан тушаалтныг илт зөрчилтэй гэж үзэн томилох эрх бүхий байгууллагад хүргүүлжээ. 2026 оны эхний байдлаар 310 мэдүүлгийг шалгаж, 22 тохиолдолд анхааруулга өгч, 3 албан тушаалтныг илт зөрчилтэй гэж дүгнэсэн байна.

Хөрөнгө, орлогын мэдүүлгийн хяналтаар 2024 онд шалгасан 40 албан тушаалтнаас 23-д нь зөрчил илэрч, хариуцлага тооцуулахаар шилжүүлсэн бол 2025 онд шалгасан 10 албан тушаалтнаас 4-т нь, 2026 онд шалгасан 14 албан тушаалтнаас 9-т нь зөрчил тогтоогдож, холбогдох байгууллагад хүргүүлсэн байна.

Авлига болон ашиг сонирхлын зөрчилтэй холбоотой өргөдөл, гомдлын тухайд 2024 онд нийслэлтэй холбоотой 19 гомдол мэдээллийг шалгаж, 2-т нь хууль тогтоомж зөрчсөн гэж үзсэн байна. 2025 онд 36 гомдол мэдээллийг шалгаснаас 9-д нь зөрчил тогтоож, эрх бүхий байгууллагад шилжүүлжээ. Харин 2026 оны эхний байдлаар 16 гомдол мэдээллийг шалгаж байгаагаас 1 тохиолдолд хууль тогтоомж зөрчсөн гэж үзэн холбогдох байгууллагад хүргүүлсэн байна.

АТГ-ын мэдээллээс үзэхэд нийслэлийн томоохон хөрөнгө оруулалтын төслүүдтэй холбоотой санхүүжилт, худалдан авах ажиллагаа, шийдвэр гаргалтын үйл явцад эрүүгийн болон ашиг сонирхлын зөрчлийн шинжтэй асуудлууд илэрч болзошгүй нөхцөл байдал үүссэн тул мөрдөн шалгах ажиллагаа үргэлжилж байгаа бөгөөд нийтийн албан тушаалтнуудын ашиг сонирхлын болон хөрөнгө орлогын мэдүүлгийн хяналтыг эрчимжүүлэн ажиллаж байгаа нь харагдаж байна.

#### **4.6. Туулын хурдны замын аудит**

Монгол Улсын Ерөнхий аудитор С.Магнайсүрэн Төрийн аудитын байгууллагаас хэрэгжүүлж буй “Туулын хурдны зам мега төслийг үр нөлөөтэй төлөвлөсөн байдал” сэдэвт гүйцэтгэлийн аудитын урьдчилсан дүнг танилцууллаа.

Аудит нь Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны шийдвэрийн дагуу 2026 оны 2 дугаар сараас эхэлсэн бөгөөд ТЭЗҮ, зураг төсөл, худалдан авах ажиллагаа, төсөвт өртөг, санхүүжилт, байгаль орчин, газар чөлөөлөлт, ил тод байдал зэрэг асуудлыг хамруулан шалгаж байгаа талаар мэдээлэв.

Аудитын урьдчилсан дүнгээр Туулын хурдны зам төсөл нь “Алсын хараа-2050”, “Шинэ сэргэлтийн бодлого”, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр болон нийслэлийн хөгжлийн бодлогын баримт бичгүүдэд тусгагдсан боловч төслийн төсөвт өртөг, санхүүжилтийн хэмжээ богино хугацаанд огцом өөрчлөгдсөн байна. Тухайлбал, 2016 онд магадлалаар баталгаажсан төсөвт өртөг 594,8 тэрбум төгрөг байсан бол 2024 онд 916,3 тэрбум төгрөг болж шинэчлэгдсэн, улмаар 2025 онд 1,9 их наяд төгрөгөөр тендер зарлаж, дараа нь 2,3 их наяд төгрөг болгон нэмэгдүүлсэн нь аудитын шалгалтын гол асуудлын нэг болж байгааг онцолсон.

Үндэсний аудитын газраас мэдээлснээр Зам тээврийн сайд, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч нарын 2025 оны хамтарсан шийдвэрээр төслийн төсөвт өртгийг 1,9 их наяд төгрөг байхаар тооцож, тендерийн баримт бичигт тусгасан байна. Энэ төсөвт өртөг нь магадлалаар баталгаажаагүй бөгөөд энэ асуудлаар холбогдогч 2 байгууллагаас аудитын явцад тайлбар ирүүлээгүй байна.

Түүнчлэн 1.9 их наяд төгрөгийн төсөвт өртгөөр зарласан анхны тендер амжилтгүй болсон бөгөөд хоёр дахь сонгон шалгаруулалтаар БНХАУ-ын компанийн түншлэл шалгарсан байна. Төсөвт өртгийн өөрчлөлт, магадлалын үндэслэл, тендерийн баримт бичгийн хууль тогтоомжид нийцсэн эсэх асуудлыг аудитын тайланд нарийвчлан дүгнэхээр ажиллаж байгааг мэдээлэв.

Санхүүжилтийн хувьд төслийн төсөвт өртгийг НИТХ хэд хэдэн удаа өөрчилж баталсан бөгөөд 2025 онд 500 тэрбум төгрөг, 2026 онд 800 тэрбум төгрөгийн санхүүжилт төлөвлөснөөс гүйцэтгэгчид нийт 500 тэрбум төгрөгийн урьдчилгаа санхүүжилт олгосон байна. Үүнээс гадна зураг төсөл шинэчлэх, газар чөлөөлөх, зөвлөх үйлчилгээ авах зэрэг ажилд 7.8 тэрбум төгрөгийн нэмэлт зардал гарсан талаар дурдсан.

Байгаль орчны асуудлын хүрээнд усны сан бүхий газрын ашиглалттай холбоотой зарим хуульд заасан зөвшөөрөл, дүгнэлт авагдаагүй, мөн төслийг хэрэгжүүлэхэд шаардлагатай 15 зөвшөөрлөөс 4 зөвшөөрөл дутуу байгааг тогтоосон байна. Тухайлбал газар эзэмших зөвшөөрөл, түгээмэл тархацтай ашигт малтмал ашиглах зөвшөөрөл, хаягдал ус зайлуулах зөвшөөрөл, усны сан бүхий газрын ашиглалтын төслийн дүгнэлт авагдаагүй байжээ. Мөн байгаль орчны менежментийн төлөвлөгөө батлагдаагүй, археологи, палеонтологи, түүх соёлын хайгуул судалгаа бүрэн хийгдээгүй байхад төслийн ажил эхэлсэн нөхцөл байдал илэрсэн байна.

Газар чөлөөлөлтийн хувьд төслийн трасст өртсөн 112 нэгж талбараас 2026 оны 6 дугаар сарын байдлаар 56 нэгж талбарыг чөлөөлсөн бөгөөд трассын давхцал, Туул голын хамгаалалтын бүсэд хамаарах асуудлуудыг аудитын хүрээнд үргэлжлүүлэн шалгаж байгаа талаар мэдээлэв.

Ерөнхий аудиторын мэдээллээс үзэхэд Туулын хурдны зам төслийн төлөвлөлт, төсөвт өртгийн өсөлт, тендер шалгаруулалт, санхүүжилт, зөвшөөрөл, байгаль орчны шаардлага, газар чөлөөлөлттэй холбоотой асуудлууд аудитын хяналтад байгаа бөгөөд аудитын урьдчилсан дүнгээр хууль тогтоомжийн хэрэгжилт, төсвийн үр ашиг, төслийн бэлэн байдалтай холбоотой хэд хэдэн эрсдэл илэрсэн байна. Аудитын тайлангийн төсөлд нийт 12 зөвлөмж, 4 албан шаардлага тусгахаар төлөвлөж байгаа бөгөөд эцсийн тайланг 2026 оны 6 дугаар сарын 30-ны өдөр Улсын Их Хурлын Төсвийн байнгын хороо болон холбогдох байгууллагад хүргүүлэхээр ажиллаж байгааг танилцууллаа.

#### **4.7.Зам тээврийн яамны бодлого ба Нийслэлийн зам тээврийн мега төслүүдийн үйл ажиллагааны уялдаа холбоо**

Зам, тээврийн яамны Авто замын бодлого, зохицуулалтын газрын дарга Ч.Сугармаа нийслэлд хэрэгжиж буй зам, тээврийн мега төслүүдийн бодлогын уялдаа холбооны талаар мэдээлэл хийв. Танилцуулгын агуулга Туулын хурдны зам, 1, 2 дугаар тойрог зам, метро, трамвай, дүүжин тээвэр, тусгай замын автобус (BRT) зэрэг төслүүдийг Монгол Улсын болон нийслэлийн хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигтэй уялдуулан хэрэгжүүлж байгаа талаар байсан боловч яамны зүгээс Тойрог хурдны замын төслүүдийг үе шат, он цагийн дараалал танилцуулж байгаад сонсгол даргалагчийн зүгээс хүндэтгэх шалтгаангүй, хангалттай бэлтгээгүй байна хэмээн шүүмжлэлтэй хандсан.

Туулын хурдны замын төслийн ТЭЗҮ-г Зам, тээврийн яамны Шинжлэх ухаан, технологийн дэд зөвлөлөөр хэлэлцүүлж, трассын сонголт, геодезийн болон гидрологийн судалгааг нарийвчлах, байгаль орчин, ус, эрчим хүчний байгууллагуудын санал тусгах, Туул голын сав газрын зөвшөөрөл авах, замын аюулгүй байдлын тоноглолуудыг төлөвлөх, түр замын зураг төсөл боловсруулах,

гүүрийн тоо хэмжээ, геологийн судалгаа, ачааллын тооцооллыг дахин нарийвчлах зэрэг техникийн болон инженерийн олон чиглэлийн зөвлөмж хүргүүлсэн байна.

Мөн нийслэлийн авто замын түгжрэлийн тооцоо, зорчилтын өгөгдлийг сайжруулах, төмөр замын шилжилтийн хувилбаруудтай харьцуулсан судалгаа хийх, орц гарцын шилжилтийн зурвас төлөвлөх, Туул голын ай савыг хамгаалах арга хэмжээг тусгах, барилга угсралтын хугацааг бодитоор тооцох, шинэ техник технологи, норм стандартыг ашиглах, явган зорчигчийн хөдөлгөөний судалгаа хийх, трасст өртөх газрын хэмжээг боломжит хамгийн бага түвшинд байлгах шаардлагатайг онцолжээ.

Түүнчлэн Туулын хурдны замын төслийн ТЭЗҮ боловсруулах явцад эрх зүйн болон оюуны өмчтэй холбоотой асуудлыг нягтлах шаардлагатай талаар зөвлөмж өгсөн байна. Тодруулбал, 2014 онд боловсруулсан ТЭЗҮ-г шинэчлэн ашиглаж байгаа нөхцөлд тухайн үеийн ТЭЗҮ боловсруулагч “Эм Си Пи Си” компанийн зохиогчийн эрхийн асуудал, зураг төсөл болон ТЭЗҮ боловсруулах тусгай зөвшөөрөл нь Зам, тээврийн сайдын тушаалаар хүчингүй болсон эсэхийг магадлах шаардлагатай гэж үзжээ.

Зам, тээврийн яамнаас өгсөн дээрх зөвлөмжүүдийн хэрэгжилтийн талаар Нийслэлийн Замын хөгжлийн газраас тодруулахад зөвлөмжүүдийг нарийвчилсан зураг төсөл боловсруулах шатанд тусган ажиллаж байгаа талаар мэдээлсэн байна.

#### **4.8. Байгаль орчны зөрчил**

Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд Ц.Сандаг-Очир Туулын хурдны зам төслийн хэрэгжилтийн явцад илэрсэн байгаль орчны зөрчил, авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар мэдээлэл танилцууллаа. Мэдээллийг байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ, байгаль орчны менежментийн төлөвлөгөө, усны нөөц, ой модны экологийн асуудал гэсэн дөрвөн чиглэлээр танилцуулсан байна.

Төслийн байгаль орчны төлөв байдлын үнэлгээг “Мон газар экологи” ХХК 2025 онд боловсруулж, Байгаль орчны ерөнхий үнэлгээгээр нарийвчилсан үнэлгээ хийх шаардлагатай гэж дүгнэсэн байна. Улмаар Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайланг мэргэжлийн зөвлөлийн хурлаар хэлэлцэн засварын дараа 2026 оны 3 дугаар сарын 19-ний өдөр баталжээ.

Харин тухайн жилийн Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг 2026 оны 4 дүгээр сарын 17-ны өдөр баталсан байна.

Шалгалтаар төслийн гүйцэтгэгч “Хаоюань Женерал Констракшн” ХХК нь Байгаль орчны менежментийн төлөвлөгөө батлагдаагүй байхад төслийн үйл ажиллагааг эхлүүлсэн нь тогтоогджээ. Үүнтэй холбогдуулан Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайдын 2026 оны 4 дүгээр сарын 07-ны өдрийн хурлаар төслийн үйл ажиллагааг түр зогсоож, менежментийн төлөвлөгөөг боловсруулан батлуулах үүрэг өгсөн байна. Мөн байгаль орчны үнэлгээнд тусгагдсан шаардлагыг биелүүлээгүй, ойн тухай хууль болон ус ашиглахтай холбоотой хууль тогтоомжийн шаардлагыг зөрчсөн асуудлаар зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа явуулж, хуульд заасан арга хэмжээ авчээ.

Усны нөөцийн асуудлаар төслийн барилга угсралтын үед технологийн болон ахуйн хэрэглээнд их хэмжээний ус ашиглахаар төлөвлөсөн бөгөөд технологийн усыг Туул голоос авах зохицуулалттай байжээ. Гэвч төслийн геологи, хайгуулын ажлын явцад усыг зохих зөвшөөрөл, гэрээгүй ашигласан зөрчил илэрч, Зөрчлийн тухай хуульд заасны дагуу 5,000 нэгжтэй тэнцэх хэмжээний торгууль ногдуулсан байна. Мөн өрөмдлөгийн ажилд ашигласан химийн бодистой холбоотой асуудлыг Экологийн цагдаагийн албанд шилжүүлэн шалгуулж эхэлсэн талаар мэдээлэв. Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр усны орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах 29 зөвлөмжийг тусгажээ.

Ойн экологийн асуудлын хүрээнд замын трасст нийт 43.2 га талбай дахь бургас, улиасан ой өртөхөөр байгааг тогтоож, экологи-эдийн засгийн үнэлгээг 805.0 сая төгрөгөөр тооцсон байна. Гэвч туслан гүйцэтгэгч “Дорно Улзын Мандал” ХХК нь байгаль орчны үнэлгээнд тусгагдсан зөвлөмжийг мөрдөөгүй, өсвөр болон залуу моддыг шилжүүлэн суулгалгүйгээр тайрч, нийт 7.2 га талбайн дунд насны улиас, бургасан ойг сүйтгэсэн зөрчил гаргасан нь тогтоогджээ. Үүнтэй холбогдуулан Зөрчлийн тухай хуулийн дагуу 500 нэгжтэй тэнцэх хэмжээний торгууль ногдуулж, 352.0 сая төгрөгийн нөхөн төлбөр төлүүлэх шийдвэр гаргасан байна. Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээнд ой, модлог ургамалд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах 19 зөвлөмжийг тусгасан талаар мэдээлэв.

Сайд Ц.Сандаг-Очирын мэдээллээс үзэхэд Туулын хурдны зам төслийн хэрэгжилтийн явцад байгаль орчны менежментийн төлөвлөгөө батлуулаагүйгээр үйл ажиллагаа эхлүүлсэн, ус ашиглах зөвшөөрлийн дэглэм зөрчсөн, мод, сөөг хамгаалах шаардлагыг хангаагүй зэрэг зөрчил илэрч, холбогдох байгууллагуудаас төслийн үйл ажиллагааг түр зогсоох, торгууль ногдуулах, нөхөн төлбөр төлүүлэх болон зөрчлийн хэрэг шалгах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлсэн байна.

#### **4.9.Туул хурдны замын төслийн хүрээнд хийсэн худалдан авах ажиллагаанд хийсэн дүгнэлт**

Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Б.Энхбаяр Сангийн сайдын 2026 оны 5 дугаар сарын 18-ны өдрийн 01/5434 тоот албан бичгээр ирүүлсэн “Туулын хурдны зам” төслийн худалдан авах ажиллагаанд хийсэн шалгалтын дүнг танилцууллаа. Шалгалт нь тендер шалгаруулалтын хууль тогтоомжийн хэрэгжилт, оролцогчдын эрх зүйн байдал, санхүүгийн чадавх, туршлага болон тусгай зөвшөөрлийн шаардлагыг хангасан эсэхэд чиглэсэн байна.

Шалгалтаар Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газраас зарласан тендерт шалгарсан БНХАУ-ын “China Hyway Group Limited” болон “Tianjin Oubaiwei” компанийн түншлэлтэй холбоотой дараах зөрчлүүдийг тогтоосон байна.

Нэгдүгээрт, тендерийн материалыг компанийн худалдааны менежер Д.Золбоо цахим гарын үсгээр баталгаажуулан илгээсэн боловч түүнийг компанийн өмнөөс төлөөлөх эрхтэй болохыг нотлох захирлын итгэмжлэл ирүүлээгүй нь тендерийн баримт бичгийн шаардлагад нийцээгүй гэж дүгнэжээ.

Хоёрдугаарт, 2025 оны 6 дугаар сарын 9-ний өдрийн консорциумын гэрээгээр түншлэл байгуулсан боловч гэрээний хэрэгжилтийг захиалагчийн өмнө бүрэн хариуцах, түншлэлийг төлөөлөх нэг гишүүнийг томилоогүй нь Төрийн болон орон

нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 6.2.3 дахь заалтыг зөрчсөн гэж үзсэн байна.

Гуравдугаарт, тусгай зөвшөөрлийн баримт бичгийн бүрдэл хангалтгүй байжээ. “China Hyway Group” Ангол Улсын тусгай зөвшөөрөл ирүүлсэн бол “Tianjin Oubaiwei” компанийн ирүүлсэн Серби Улсын тусгай зөвшөөрлийн орчуулга эх хувьтайгаа зөрүүтэй байсан бөгөөд өөрийн тусгай зөвшөөрлийн оронд Серби Улсад хөрөнгө оруулан байгуулсан “OBW Construction” компанийн тусгай зөвшөөрлийг ирүүлсэн нь шаардлага хангаагүй гэж дүгнэсэн байна.

Дөрөвдүгээрт, татвар болон нийгмийн даатгалын өр төлбөргүй болохыг нотлох эрх бүхий байгууллагын албан ёсны тодорхойлолт ирүүлээгүй байна. Тухайлбал, “China Hyway Group” компани татварын өргүй тухай тодорхойлолтыг өөрөө гаргаж өгсөн бөгөөд Citibank N.A Hong Kong банкны цахим шуудан ирүүлсэн ч зээлийн мэдээллийн сангийн албан ёсны лавлагааг орлуулах боломжгүй гэж үзжээ.

Тавдугаарт, тендерт оролцогчдын санхүүгийн чадавхыг нотлох баримт дутуу байсан байна. Түншлэлээс зөвхөн Гуандун мужийн батлан даалтын компанийн зээлжих чадварын батламж ирүүлсэн боловч харилцагч банкны дансны үлдэгдэл, арилжааны банкнаас зээл авах боломжтой тухай тодорхойлолт зэрэг үндсэн баримт бичгийг ирүүлээгүй байна.

Зургаадугаарт, ижил төстэй ажил гүйцэтгэсэн туршлагыг нотлох баримтын бүрдэл хангалтгүй байжээ. Түншлэлийн компаниуд Мозамбикийн төмөр замын их засвар, Сербийн E763 хурдны зам, Луадагийн нисэх буудлын төмөр замын шугам зэрэг томоохон төслүүд хэрэгжүүлсэн тухай мэдээлэл ирүүлсэн боловч танилцуулсан таван ажлын дөрөвт нь ажлыг бүрэн гүйцэтгэсэн болохыг нотлох комиссын акт, ашиглалтад хүлээн авсан дүгнэлт зэрэг баримт бичиг байхгүй байсан тул туршлагыг баталгаажуулах боломжгүй гэж дүгнэсэн байна.

Иймээс Сангийн яамны шалгалтын дүнгээр Туулын хурдны замын төслийн тендерт шалгарсан түншлэлийн эрх зүйн төлөөлөл, түншлэлийн зохион байгуулалт, тусгай зөвшөөрөл, татварын тодорхойлолт, санхүүгийн чадавх болон ижил төстэй ажлын туршлагыг нотлох баримтын бүрдэл нь тендерийн шаардлагыг бүрэн хангаагүй гэсэн дүгнэлт гарсан талаар Б.Энхбаяр сайд сонсголд мэдээллээ.

#### **4.10.Туулын хурдны замын төслийн төсвийн зарцуулалт, холбогдох баримт бичигт хийсэн шинжээчийн дүгнэлт**

Сонсголын үеэр шинжээч С.Бат-Эрдэнэ “Туулын хурдны зам” төслийн төсөв, техник-эдийн засгийн үндэслэл, санхүүжилт, худалдан авах ажиллагаа, газар чөлөөлөлт болон төслийн хэрэгжилтийн эрсдэлийн талаар хийсэн шинжилгээний дүгнэлтээ танилцуулсан. Шинжээчийн мэдээлэлд төслийн төлөвлөлт, шийдвэр гаргалтын явц, төсөвт өртгийн өөрчлөлт, санхүүжилтийн бүтэц, газар чөлөөлөлт болон иргэдийн оролцоотой холбоотой асуудлуудыг хөндсөн болно.

Шинжээчийн танилцуулснаар Туулын хурдны зам нь УИХ-ын “Алсын хараа-2050” урт хугацааны хөгжлийн бодлого, “Шинэ сэргэлтийн бодлого”, Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөө болон Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан нийслэлийн замын сүлжээг хөгжүүлэх томоохон

төслүүдийн нэг бөгөөд Улаанбаатар хотын түгжрэлийг бууруулах зорилтын хүрээнд хэрэгжиж байгаа төсөл юм.

Төслийн зураг төсөл, ТЭЗҮ болон төсөвт өртөгт олон удаагийн өөрчлөлт орсон талаар шинжээч онцолсон. Анх Зам, тээврийн хөгжлийн төвийн 2024 оны 509/2024 дугаар магадлалын ерөнхий дүгнэлтээр 4 эгнээ, 3.8 км урт гүүрэн байгууламж бүхий төслийн төсөвт өртгийг 916,3 тэрбум төгрөгөөр баталгаажуулсан боловч дараагийн шинэчлэлтүүдээр замын хүчин чадлыг 6 эгнээ болгон өргөтгөж, гүүрэн байгууламжийн уртыг 9.9 км хүртэл нэмэгдүүлснээр төсөвт өртөг 2,384 их наяд төгрөг болж өссөн байна. Ингэснээр анхны төсөвтэй харьцуулахад нийт өртөг 2.6 дахин нэмэгдсэн гэж дүгнэжээ.

Шинжээчийн үзэж байгаагаар төсөв нэмэгдэхэд замын эгнээний тоог нэмэгдүүлсэн, гүүрэн байгууламжийн уртыг 6 орчим км-ээр өсгөсөн, усны эх үүсвэр хамгаалах болон хот байгуулалтын шийдлүүдийг өөрчилсөн, мөн Нэгдүгээр тойрог зам болон бусад хот байгуулалтын төлөвлөлттэй уялдуулан трассын өөрчлөлт хийсэн зэрэг хүчин зүйлс нөлөөлсөн байна. Тухайлбал, төмөрбетон гүүр, туннелийн ажлын төсөв 190.5 тэрбум төгрөгөөс 1.594 их наяд төгрөг болж огцом өссөн нь төсөв нэмэгдэх гол шалтгаан болсон гэж дурдсан.

Санхүүжилтийн хувьд төслийг 2025-2028 онд орон нутгийн төсөв, орон нутгийн татварын орлого болон Авто замын сангийн эх үүсвэрээр санхүүжүүлэхээр төлөвлөсөн бөгөөд 2025 онд 500 тэрбум төгрөг, 2026 онд 899 тэрбум төгрөгийн санхүүжилт батлагдсан байна.

Гэвч шинжээч зөвхөн хурдны замын ажлын өртгөөр хязгаарлахгүйгээр холбогдох дэд бүтэц, газар чөлөөлөлт, инженерийн байгууламж болон бусад нэмэлт ажлуудыг хамруулан тооцоход төслийн нийт өртөг урьдчилсан байдлаар 5.5 их наяд төгрөгт хүрэхээр байгааг онцлон тэмдэглэв. Мөн төслийн санхүүжилтэд улсын болон нийслэлийн төсвийн оролцоо давамгайлж байгаа нь төсвийн ачааллыг нэмэгдүүлэх эрсдэлтэй гэж үзжээ.

Худалдан авах ажиллагааны талаар анхны тендер шалгаруулалт амжилтгүй болж, бүх оролцогч шаардлага хангаагүй үндэслэлээр татгалзагдсан тул дахин тендер зарласан байна. Дахин зарласан тендерийн төсөвт өртөг өмнөхөөсөө 419,2 тэрбум төгрөгөөр буюу 21.3 хувиар өссөн бөгөөд энэ нь төслийн бэлтгэл, зураг төсөл, өртгийн тооцоолол тогтвортой бус байсныг илэрхийлж байна гэж шинжээч дүгнэсэн.

Мөн Сэлбэ дэд төвийн хөгжлийн төсөлтэй уялдуулан хийсэн дүн шинжилгээнд анхны төлөвлөлтөөр 23.5 мянган хүн амтай байхаар тооцсон бүсийг 48.2 мянган хүн амтай байхаар шинэчилсэн нь инженерийн дэд бүтэц, дулаан, цахилгаан, ус хангамжийн системд нэмэлт ачаалал үүсгэж байгааг тэмдэглэсэн. Зарим дэд бүтцийн шийдэл бүрэн боловсроогүй, дулааны эх үүсвэрийн асуудал эцэслэн шийдвэрлэгдээгүй, холбогдох зураг төсөл бүрэн батлагдаагүй нөхцөлд төслийн хэрэгжилт эхэлсэн нь хугацаа хойшлох болон өртөг өсөх эрсдэлийг нэмэгдүүлж байгааг онцолсон байна.

Газар чөлөөлөлтийн асуудлаар шинжээч төслийн нөлөөлөлд өртсөн иргэдтэй олон жилийн турш хамтран ажиллаж, оролцоог нь хангах чиглэлээр бэлтгэл ажил хийгдэж байсан боловч төслийн хэрэгжилтийн явцад нүүлгэн шилжүүлэлттэй

холбоотой маргаан, бизнес эрхлэгчдийн эрх ашиг, нөхөн олговрын асуудал бүрэн шийдэгдээгүй байгааг дурдсан. Тэрээр газар эзэмшигчдийн оролцоог хангаж, төслийн үр өгөөжөөс хүртэх боломжийг бүрдүүлэх хувилбарууд байсан гэж үзэж байгаагаа илэрхийлсэн.

Шинжээчийн дүгнэлтээр Туулын хурдны зам болон түүнтэй уялдсан хот байгуулалтын төслүүд нь нийслэлийн хөгжлийн бодлогын хүрээнд хэрэгжиж байгаа хэдий ч төслийн бэлтгэл хангалтгүй, дэд бүтцийн зарим шийдэл бүрэн боловсроогүй, нийт өртөг өсөх хандлагатай, санхүүжилтийн дарамт өндөр, газар чөлөөлөлт болон иргэдийн оролцоотой холбоотой эрсдэлүүд бүрэн арилгагдаагүй байгаа нь төслийн хугацаа сунжрах, төсөв нэмэгдэх, хэрэгжилтийн үр ашиг буурах эрсдэлийг бий болгож байгааг онцлон тэмдэглэв.

#### **4.11. Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам болон Нийслэлийн бүтээн байгуулалтын бодлогын уялдаа холбоо, төслүүдийн хэрэгжилтийг сайжруулах санал, дүгнэлт**

Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны Төрийн нарийн бичгийн дарга М.Баяраа нийслэлд хэрэгжиж буй 16 мега төслийн бодлого, төлөвлөлтийн уялдаа холбооны талаар мэдээлэл хийлээ. Тэрээр Нийслэлийн Нэгдсэн төслийн удирдлагын газрын 2026 оны 5 дугаар сарын мэдээлэлд үндэслэн нийслэлд нийт 16 томоохон төсөл, арга хэмжээ хэрэгжиж байгааг танилцуулсан бөгөөд эдгээр нь нийтийн тээврийн 4 төсөл, авто зам, замын байгууламжийн 3 төсөл, орон сууцжуулалтын 3 төсөл, эрчим хүч, дэд бүтцийн 4 төсөл, усны менежмент болон үерийн эрсдэлийг бууруулах 2 төслөөс бүрдэж байгааг дурдсан.

Түүний мэдээлснээр дээрх төслүүд нь Монгол Улсын урт болон дунд хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгүүд болох “Алсын хараа–2050” урт хугацааны хөгжлийн бодлого, “Шинэ сэргэлтийн бодлого”, Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан зорилт, арга хэмжээнүүдийн хүрээнд хэрэгжиж байна. Үүнд метро, LRT, BRT, дүүжин тээвэр, Шинэ тойрог зам, Туулын хурдны зам, Сэлбэ дэд төвийн орон сууцжуулах төсөл, Хүннү хотын дэд бүтцийн төсөл, Дулааны V цахилгаан станц, Туул усан сангийн цогцолбор зэрэг төслүүд багтаж байгааг танилцуулсан.

Мөн эдгээр төслүүдийн хот байгуулалтын баримт бичигтэй нийцэж буй байдлыг тайлбарласан. Улаанбаатар хотын 2030 он хүртэлх хөгжлийн чиг хандлагын баримт бичигт ихэнх төслүүд туссан бөгөөд зарим төсөл, тухайлбал дүүжин тээврийн төсөл болон Шинэ тойрог замын төсөл тусгагдаагүй байсан бол Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний төсөлд бүх 16 төсөл бүрэн тусгагдсан талаар мэдээлэв.

Төрийн нарийн бичгийн дарга М.Баяраа Улсын Их Хурлын 2013 оны 23 дугаар тогтоолоор батлагдсан “Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний тодотгол, 2030 он хүртэлх хөгжлийн чиг хандлага”-ын баримт бичгийн хэрэгжилтийн хугацаа дууссан бөгөөд шинэ төлөвлөлтийн баримт бичиг боловсруулах шаардлага үүссэнийг онцолсон. Энэ хүрээнд “Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөө”-г 2017 оноос боловсруулж, 2025 оны 1 дүгээр сарын 8-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн бөгөөд одоогоор Байнгын хороодын хэлэлцүүлгийн шатанд байгаа талаар танилцуулсан.

Тэрээр 2040 оны хөгжлийн ерөнхий төлөвлөгөө батлагдсаны дараа түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулж Засгийн газрын тогтоолоор батлуулах шаардлагатайг тэмдэглэв. Ингэснээр нийслэлд хэрэгжиж буй 16 мега төсөл тус төлөвлөгөөнд нэгтгэгдэж, улсын хэмжээний хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигтэй уялдсан нэгдсэн зохицуулалттайгаар хэрэгжих нөхцөл бүрдэх юм гэж үзэж байгаагаа илэрхийлсэн.

Мөн Хот байгуулалтын тухай хуулийн 8.1.6 дахь заалтад аймаг, нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний үе шатны төсөл, хөтөлбөр, төлөвлөгөөг хот байгуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн батлах үүрэгтэй гэж заасныг онцлон дурдсан. Иймээс нийслэлд хэрэгжиж буй томоохон бүтээн байгуулалтын төслүүдийг салбарын бодлого, хот байгуулалтын ерөнхий төлөвлөгөөтэй нягт уялдуулан хэрэгжүүлэх шаардлагатай гэсэн байр суурийг илэрхийлсэн.

Илтгэлийн төгсгөлд Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөө болон түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг яаралтай баталж, нийслэлийн бүтээн байгуулалт, дэд бүтэц, орон сууцжуулалтын төслүүдийг нэгдсэн бодлого, төлөвлөлтийн хүрээнд хэрэгжүүлэх нь зүйтэй гэсэн дүгнэлтийг хийсэн байна.

#### **4.12.Сэлбэ дэд төв орон сууцжуулах төслийн техник эдийн засгийн үндэслэл, зураг төсөл батлагдсан үйл явцын талаар**

Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны Төрийн нарийн бичгийн дарга М.Баяраа Сэлбэ дэд төвийн орон сууцжуулах төслийн ТЭЗҮ, зураг төсөл болон хэрэгжилтийн явцын талаар мэдээлэл хийлээ.

Тэрээр УИХ-ын 2013 оны 23 дугаар тогтоолоор батлагдсан Улаанбаатар хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнд нийслэлийг нэг төвт хотоос олон төвт хот болгон хөгжүүлэх бодлого тусгагдсан болохыг онцлов. Энэ хүрээнд Толгойт, Баянхошуу, Сэлбэ, Дэнжийн мянга, Шархад, Дамбадаржаа зэрэг зургаан дэд төвийг байгуулж хөгжүүлэхээр төлөвлөсөн бөгөөд “Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөө”-ний төсөлд уг бодлогыг үргэлжлүүлэн хэрэгжүүлж, нийслэлийг “20 минутын олон төвт хот” болгон хөгжүүлэх зорилтыг дэвшүүлсэн байна.

Сэлбэ дэд төвийн төслийн хүрээнд Чингэлтэй дүүргийн 14, 18 дугаар хороо, Сүхбаатар дүүргийн 14 дүгээр хорооны нутаг дэвсгэрийг хамарсан 158 га талбайд гэр хорооллыг дахин төлөвлөн орон сууцжуулахаар шийдвэрлэсэн байна. Төслийн хэрэгжилтийн мэдээллээс үзэхэд Сэлбэ дэд төвийг хөгжүүлэх ТЭЗҮ хоёр удаа боловсруулагдсан бөгөөд эхнийх нь Азийн хөгжлийн банкны техникийн туслалцааны хүрээнд, хоёр дахь нь 2015 оны хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний хүрээнд хийгджээ.

Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 61 дүгээр тогтоолоор төслийн 58 га талбайн хил заагийг баталж, улмаар ТЭЗҮ болон барилгажилтын төсөл боловсруулах сонгон шалгаруулалтыг зохион байгуулан “Би Би Эс Мо” ХХК-ийг гүйцэтгэгчээр сонгосон байна. Тус компанийн боловсруулсан ТЭЗҮ-г Барилгын

хөгжлийн төвийн магадлалаар зөвшөөрч, барилгажилтын төслийг нийслэлийн Ерөнхий архитектор баталжээ.

Төслийн төлөвлөлтөөр нийт 12,032 өрхийн хэрэгцээг хангах орчин бүрдүүлэхээр тооцсон бөгөөд үүнээс 8,575 өрхийг нийтийн зориулалттай орон сууцанд, 3,457 өрхийг үйлчилгээтэй орон сууц болон амины орон сууцны бүсэд байршуулахаар төлөвлөсөн байна. Барилгажилтын хувьд нийтийн орон сууцны барилгуудыг 9-12 давхар, үйлчилгээтэй орон сууцыг 22 хүртэл давхар, амины орон сууцыг 3 давхар байхаар төлөвлөжээ.

Нийгмийн дэд бүтцийн хүрээнд 3,780 хүүхдийн хүчин чадалтай гурван сургууль, 1,200 хүүхдийн хүчин чадалтай таван цэцэрлэг байгуулахаар тусгасан байна. Мөн төрийн үйлчилгээ, худалдаа үйлчилгээний байгууламжуудыг цогцоор нь төлөвлөсөн бөгөөд нийт 113 блок орон сууц баригдахаар зураг төсөлд тусгагдсан байна.

Төслийн хэрэгжилтийн явцын тухайд 2026 оны 5 дугаар сарын байдлаар нийт төслийн гүйцэтгэл 32.06 хувьтай байгаа талаар мэдээлсэн. Харин газар чөлөөлөлтийн ажил өндөр хувьтай хэрэгжиж, төслийн нөлөөлөлд өртсөн 2,206 нэгж талбараас 1,911 нэгж талбартай гэрээ байгуулж, нийт газар чөлөөлөлтийн ажил 95 хувийн гүйцэтгэлтэй болсон байна. Үүнээс орон сууцны бүсийн газар чөлөөлөлт 97.2 хувь, олон нийтийн бүсийн газар чөлөөлөлт 92 хувь, нийгмийн дэд бүтцийн зориулалттай газрын чөлөөлөлт 97.8 хувийн биелэлттэй байгаа талаар танилцуулсан.

Төслийн хүрээнд 2,206 өрхийн хашаа байшинг чөлөөлөхөд нийслэлийн төсвөөс нийт 405 тэрбум төгрөг зарцуулсан бөгөөд нэг өрхийн газрыг дунджаар 183,6 сая төгрөгөөр чөлөөлсөн байна. Гэвч газар чөлөөлөлтөд хамрагдсан иргэдийн цаашдын орон сууцны нөхцөл, шилжилт хөдөлгөөн, нөхөн олговрын хөрөнгийг хэрхэн ашигласан талаарх мэдээлэл тодорхой бус байгааг М.Баяраа онцлон тэмдэглэв.

Төслийн санхүүжилтийг нийслэлийн бонд болон төслийн өөрийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн бөгөөд орон сууцны борлуулалтын нийт орлогыг 2,48 их наяд төгрөгөөр тооцсон байна. Үүнээс орон сууцны борлуулалтаас 2,37 их наяд төгрөг, дулаан зогсоолын борлуулалтаас 107,4 тэрбум төгрөгийн орлого төвлөрүүлэхээр төлөвлөжээ. Нийт 8,575 айлын орон сууцнаас 3,000 айлыг төрийн албан хаагчдад, 858 айлыг гүйцэтгэгч компанид олгохоор урьдчилсан байдлаар тооцсон байна.

М.Баяраа илтгэлийн төгсгөлд гэр хорооллыг дахин төлөвлөхдөө Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хуулийн 18.3-т заасан “газрыг орон сууцаар солих” хэлбэрийг түлхүү хэрэглэх нь иргэдийн амьдрах нөхцөлийг сайжруулах, дахин яндан бүхий суурьшил үүсгэхгүй байх, нийгмийн үр өгөөжийг нэмэгдүүлэх ач холбогдолтой гэж үзэж байгаагаа илэрхийлсэн. Мөн төр өөрөө орон сууц барьж зах зээлд борлуулах нь хувийн хэвшилтэй өрсөлдөх эрсдэлтэй тул төрөөс газар болон инженерийн дэд бүтцийг бэлдэж, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг татан оролцуулах нь илүү оновчтой загвар болохыг онцолсон байна.

Үүнтэй холбоотойгоор орон сууцжуулалтын бодлогыг шинэ түвшинд зохицуулах зорилгоор боловсруулсан Орон сууцжуулалтын тухай хуулийн төслийг

2026 оны 6 дугаар сарын 11-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн бөгөөд дээрх зохицуулалтуудыг тус хуульд тусгасан талаар мэдээлэв.

#### **4.13. Сэлбэ дэд төв орон сууцжуулах төслийн нийт хөрөнгө оруулалтын гүйцэтгэл, Сэлбэ хорин минутын хот төслийн төсвийн гүйцэтгэл, холбогдох баримт бичигт хийсэн шинжээчийн дүгнэлт**

Сэлбэ дэд төвийн төслийн хүрээнд 158 га талбайд гэр хорооллыг дахин төлөвлөж, 8575 айлын нийтийн орон сууц, 3457 айлын амины болон үйлчилгээтэй орон сууц, 3 сургууль, 5 цэцэрлэг барихаар төлөвлөсөн байна. Төслийн хэрэгжилтийн хүрээнд нийт 2206 өрхийн газар, үл хөдлөх хөрөнгийг чөлөөлөхөд 405.0 тэрбум төгрөг зарцуулсан бөгөөд нэг өрхөд дунджаар 183.6 сая төгрөгийн нөхөн олговор олгосон талаар шинжээч З.Туяа, Э.Батболд, Д.Энхбаяр нар дүгнэлтээ танилцууллаа.

Мөн анх Азийн хөгжлийн банкны төслийн хүрээнд 23,500 хүн амтай байхаар төлөвлөж байсан Сэлбэ дэд төвийн хүн амын багтаамжийг 2024 оны шинэчилсэн төлөвлөлтөөр 48,200 хүн болгон нэмэгдүүлсэн нь дулаан, цахилгаан, ус хангамж болон бусад инженерийн дэд бүтцийн ачааллыг эрс өсгөсөн талаар дурдсан. Шинжээчийн тооцооллоор төслийн нийт хөрөнгө оруулалтын хэмжээ 5.5 их наяд төгрөгт хүрэхээр байгаа бөгөөд санхүүжилтийн бүтцэд улсын болон нийслэлийн төсвийн эх үүсвэр 45 орчим хувийг эзэлж байгаа нь төсвийн өндөр ачаалал үүсгэх эрсдэлтэй гэж үзжээ.

Түүнчлэн төслийн нийт ажлын гүйцэтгэл дунджаар 18-20 хувийн түвшинд байгаа бөгөөд нүүлгэн шилжүүлсэн иргэдийн амьдралын нөхцөл, үр нөлөөг үнэлсэн мөшгөх судалгаа хийгдээгүй, шаардлагатай дулааны нэмэлт 48 МВт эх үүсвэр бүрэн шийдэгдээгүй, цаашид баригдах орон сууцны борлуулалтын үнэ гэр хорооллын иргэдийн худалдан авах чадварт нийцэх эсэх нь тодорхойгүй зэрэг эрсдэлүүд байгааг онцлон тэмдэглэсэн байна.

#### **ТАВ.ОРОЛЦОГЧ ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГА, ИРГЭДИЙН САНАЛ, ТАЙЛАР, МЭДЭЭЛЭЛ, БАЙР СУУРЬ**

Оролцогч төрийн бус байгууллага, иргэдийн төлөөлөл хоёр өдрийн турш идэвхтэй оролцов. Эхний өдөр танхимаас 3 иргэн үг хэлж, 10 иргэний бичгээр ирүүлсэн санал, асуултыг уншиж танилцуулсан. Хоёр дахь өдөр 24 орчим иргэн, ТББ-ын төлөөлөл үг хэлсэн. Гол санал, шаардлагуудыг ангилбал:

##### **5.1.2026 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн санал**

- Хөрөнгө оруулалтын төслүүдийн явц, хугацаа хожимдол, төсөвт өртөг нэмэгдсэн шалтгааныг тодруулах; метро, трамвай, хурдны зам зэрэг төслийг хямд, оновчтой өртгөөр хэрэгжүүлэх (иргэн Б.Дөлгөөн);
- Бондын мэдээллийг СЗХ, Монголбанкны сайтад үнэн зөв байршуулах; андеррайтерийн үйлчилгээ үзүүлэгч ҮЦК-ийн аудитын дүгнэлтийг хянах; соёлын биет/биет бус өвийн судалгаа хийдэг болох; аудит, бондын эрх зүйн орчныг сайжруулах (иргэн Б.Ганбаяр);

- Шүгэл үлээгчийн эрх зүйн байдлын тухай, Төсвийн удирдлагын тухай хуулийг яаралтай өргөн барих; сонсголд цуглуулсан материалыг ил тод болгох; нийслэл жил бүр төсвийн хяналтын сонсгол хийх; нийслэлийн өмчит ААН данхайсныг цэгцлэх (иргэн Б.Өлзийбат);

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд заасны дагуу урьдчилан бичгээр ирүүлсэн саналд: Сэлбэ дахин төлөвлөлтийн газар чөлөөлөлтийн гомдол (Б.Нямаасүрэн), төсвийг ил тод болгох (М.Одбаяр, О.Отгонбаяр), голуудын засварын төсөв, БОННУ, ТЭЗҮ-г шалгах (Ж.Өсөхбаяр), явган замын аюулгүй байдал (Д.Энхтүвшин), тендерт давтан шалгарсан компаниудын асуудал (Д.Энхтуул), Гандан орчмын газар чөлөөлөлт (Г.Эрдэнээ), Туулын хурдны замын НИТХ-ын шийдвэрийг шүүхэд маргаалж буй (Ц.Батболд) зэрэг асуудал хөндсөн.

## 5.2.2026 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн санал

- Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дарга Ж.Дэлгэрсайхан: нийслэлийн төсвийн бие даасан байдал, бонд гаргалт нэгдсэн төсвийн тогтвортой байдлыг алдагдуулах эрсдэлтэй; Төсвийн тухай хуулийн 57.2, 57.3 заалтын хийдлийг арилгах шаардлагатай;

- Инженер Л.Ану-Үжин: 7 зам тээврийн төсөл (26.8 их наяд, ДНБ-ийн 32%) хоорондын нэгдсэн төлөвлөлт, тооцоо байхгүй; өвлийн матрицыг хуучирсан 2007, 2017 оны судалгаагаар тооцсон; БРТ хамгийн боломжтой, 2 дугаар тойрог зам, Туулын хурдны зам хамгийн асуудалтай;

- Ерөнхий шаардлага: төсөв, мега төслийн мэдээллийг бодитоор ил тод болгох (нэгдсэн дата систем); нийслэлийн өмчит ААН-ийн өсөлтийг хязгаарлах; төрийн албан тушаалтнуудад хариуцлага тооцох; иргэдийг ажил, орлоготой болгох замаар түгжрэлийг шийдэх; нийслэлийн өмнөх удирдлага (Х.Нямбаатар)-аас хариуцлага нэхэх (иргэн Г.Гэрэлмаа, Г.Гүррагчаа, Б.Мөнхсайхан нар);

- Монголын Барилгачдын нэгдсэн холбоо (Б.Өлзийбат): Сэлбэ дэд төвийн ажлыг гадаадын хоёр компанид өгөхөөр байсныг тэмцэж, Монгол ААН-үүдийг оролцуулсан; Монгол барилгачид чадварлаг тул төр итгэх ёстой;

- Хоёр өдрийн сонсголыг хаах үед иргэдээс 2 хүсэлт ирүүлсэн: (1) нийслэлийн хуучин болон одоогийн удирдлагуудтай хариуцлага тооцох тухай шаардлага (Г.Гүррагчаа, З.Гэрэлт-Од, Б.Мөнхсайхан нарын гарын үсэгтэй); (2) тусгай хэрэгцээт иргэдийн эрхийн талаарх хүсэлт (П.Нямдэлгэр);

Тус өдрийн сонсголд иргэн Г.Уянга Туулын хурдны замын төслийг эсэргүүцэн ажиллаж буй иргэдийн төлөөллийн хувиар оролцож, төслийн хэрэгжилттэй холбоотойгоор иргэдийн оролцоо, мэдээллийн хүртээмж, байгаль орчны асуудлыг хөндсөн танилцуулга хийв. Тэрээр иргэд Үндсэн хуулиар хүлээсэн байгаль орчноо хамгаалах үүргийн хүрээнд Туул голын сав газрын мод, бут сөөг устаж байгаа талаар анхаарал хандуулж, 2026 оны 03 дугаар сараас эхлэн эсэргүүцлийн арга хэмжээнүүдэд оролцсон талаар мэдээлсэн.

Түүний танилцуулгад төслийн гүйцэтгэгч байгууллагын үйл ажиллагаа, байгаль орчны нөлөөллийн үнэлгээ, усны нөөцөд үзүүлэх нөлөөлөл, төслийн хэрэгжилтийн явцад төрийн байгууллагуудаас иргэдэд өгсөн мэдээллийн үнэн зөв байдалд эргэлзэж буйгаа илэрхийлсэн. Мөн төслийн хүрээнд мод бут устгах ажил, өрөмдлөгийн ажил үргэлжилж байсан талаар өөрийн ажиглалт, цуглуулсан мэдээллийг танилцуулсан байна.

Түүнчлэн иргэн өөрөө болон гэр бүлийнхэнд нь дарамт шахалт, сүрдүүлэг ирсэн гэж үзэж байгаагаа илэрхийлж, энэ талаар Хүний эрхийн Үндэсний Комисс, цагдаагийн байгууллага болон бусад эрх бүхий байгууллагад хандсан тухай мэдээлэл өгсөн.

Илтгэлийн хүрээнд төслийн гүйцэтгэгч компанийн туршлага, байгаль орчны үнэлгээний баримт бичиг, төслийн хэрэгжилтийн хууль эрх зүйн үндэслэлтэй холбоотой асуудлаар иргэн өөрийн хийсэн судалгаа, цуглуулсан баримт мэдээллийг танилцуулж, холбогдох байгууллагуудаас илүү нээлттэй, ил тод мэдээлэл өгөх шаардлагатай гэж үзэж байгаагаа илэрхийлэв.

## **ЗУРГАА.УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮДИЙН АСУУЛТ, ХАРИУЛТ**

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 126 дугаар зүйлийн 126.1.5-д заасны дагуу нэг гишүүнд 20 хүртэл минут олгож, олонх-цөөнхийн төлөөллийг ээлжлүүлэн зохион байгуулсан.

### **6.1.2026 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн УИХ-ын гишүүдийн асуулт, хариулт**

<b>Асуулт асуусан УИХ-ын гишүүн</b>	<b>Асуултын агуулга</b>	<b>Хариулт өгсөн албан тушаалтан</b>
Дав.Цогтбаатар	Хяналтгүй “мега хулгай”, бүх төлөөлөгчийг хуулийн байгууллагаар шалгуулах; Эмээлт парк ба МБУ компанийн зээл; Туулын замын трассын тогтоол; ашиг сонирхлын зөрчил	О.Одбаяр (ХБОСС), Б.Мягмар (Эмээлт парк), Б.Пүрэвдагва (НЗД)
Ч.Лодойсамбуу	80 орчим компани байгуулсан эрх зүйн үндэслэл, хувийн хэвшил гүйцэтгэх боломжтой эсэх; ИТХ-ын төлөөлөгчдийн ашиг сонирхлын зөрчил; цаашид яаж шийдвэрлэх	Б.Пүрэвдагва, М.Халтар (НИТХ), Г.Азжаргал (АТГ)
Б.Мөнхсоёл	Мэдээллийн ил тод байдал, Туулын замын мэдээлэл; Сэлбэ дэд төвийг 100% нийслэлийн бондоор санхүүжүүлж буй шалтгаан; албан бичгийн хариу ирээгүй	Б.Пүрэвдагва, У.Баатар (Сэлбэ корп.)
Н.Алтаншагай	Хашлага (бордюр), авто замын засвар стандарт; СХД-ийн бейсболын талбайн газар, зураг төсөв	Б.Одбаяр (Замын хөгжил), Б.Гантулга (НЗДТГ)
Р.Батболд	Алдагдалтай төсөв батлах; нийслэлийн өртөг улсынхаас/хувийн хэвшлээс өндөр болох шалтгаан; бордюр, явган замын татан авалтын нөөц	Л.Эрдэнэбадрах (НЗДТГ Санхүү), Б.Мөнхбат (орлогч дарга)

*“Нийслэлийн 2024–2026 оны төсвийн зарцуулалт, хөрөнгө оруулалтын төслүүдийн хэрэгжилт холбогдох хууль тогтоомжид нийцсэн байдал” сэдэвт Ерөнхий хяналтын сонсголын тайлан*

П.Ганзориг	Тогтолцооны гажуудал; сонгуулийн тогтолцоо, холимог систем; хотын даргыг иргэдээс шууд сонгох; ИТХ-ын бие даасан байдал	Б.Пүрэвдагва
П.Сайнзориг	16 төслийн бодлогын баримт бичигтэй уялдаа; нийслэлийн онцгой статус (Capital City); засаг захиргааны шинэчлэл	Э.Түвшинжаргал (НТУГ)
Ж.Баярмаа	Дүүжин тээврийн маршрут, үр ашиг; Сэлбэ корп. ба НОСК-ийн давхардал; хүнсний зах; эрчим хүчний нэгдсэн бодлого; төслийн эрэмбэлэлт; АТГ-ийн тоон мэдээлэл	Б.Одбаяр, Э.Түвшинжаргал, И.Лувсанцэрэн (ЭХЯ), Б.Мөнхбат, М.Санжаадорж (СЯ)
О.Батнайрамдал	Шинжээчдийн хугацаа хүрэлцээтэй эсэх; 2.4 их наяд алдагдлын нягтлан бодох бүртгэлийн тайлбар; нийслэлийн бонд гаргах эрхийг буруутгаж болохгүй	М.Санжаадорж (СЯ), шинжээч Д.Энхбаяр

**Дүн:** Эхний өдрийн асуулт-хариултын хэсэгт нийт 9 гишүүн оролцов. Сонсгол даргалагч Ж.Золжаргал нэмэлт тодруулах асуулт тавьж (хүнсний 5 компани → Б.Мөнхбат, “Улаанбаатар хөрөнгө оруулалт менежмент” ҮЦК → Г.Гангамөрөн) хариулт авсан.

**6.1.2026 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн УИХ-ын гишүүдийн асуулт, хариулт**

Асуулт асуусан УИХ-ын гишүүн	Асуултын агуулга	Хариулт өгсөн албан тушаалтан
Д.Үүрийнтуяа	Магадлалын зөрүү (916.3 / 1.9 / 2.3 их наяд); аудитын дүн зам тээврийн бодлоготой уялдаагүй; яагаад өмнө нь дүгнэлтээр илрээгүй	Б.Батчимэг (ҮАГ), Ч.Сугармаа (ЗТЯ), Д.Оюунболд (ЗТХТ), З.Энх-Оргил (БХТ)
Р.Батболд	Сэлбэ дэд төвийн өртөг (м <sup>2</sup> ), магадлал хийдэг журам; барилгын тендерт Монгол ААН-ийн оролцоо; 20 минутын хот ба Туулын замын логик уялдаа	З.Энх-Оргил (БХТ), Ц.Батзул (ТХААГ)
Б.Мөнхсоёл	500 тэрбум төгрөгийн урьдчилгаа төлбөрийн бодит зарцуулалт, эргэн авах боломж, захиалагчийн хяналт; ТХХТ-ийн эрх зүйн үндэслэл	Б.Одбаяр (Замын хөгжил)
Д.Энхтүвшин	“Утаа”, “түгжрэл”-ийг хэмжих нэгж, аргачлал; 16 төсөл тус бүр хэдэн нэгжээр бууруулах, эрэмбэлэлт	Б.Одбаяр, У.Баатар (Сэлбэ), П.Хадбаатар (НЗДТГ Бодлого)
Д.Цогтбаатар	Туулын зам, Сэлбэ төслийн хэрэгжилт, хяналт, хариуцлагын асуудал	Нийслэл, холбогдох албадын төлөөлөл
П.Сайнзориг	Засаглал, төсвийн бодлого, нийслэлийн статус, бэлтгэлгүй реформын эрсдэл	Шинжээч З.Туяа, нийслэлийн төлөөлөл
Ж.Баярмаа	Гуравхан сард 900 тэрбум → 1.9 их наяд болсон үндэслэл; магадлалгүй/зураг төсөвгүй 75 төсөл; байгаль орчны менежментийн төлөвлөгөө; химийн бодис	С.Магнайсүрэн (Ерөнхий аудитор), Г.Нандинжаргал (Нийслэл аудит), А.Алтанзул (БОУАӨЯ),

*“Нийслэлийн 2024–2026 оны төсвийн зарцуулалт, хөрөнгө оруулалтын төслүүдийн хэрэгжилт холбогдох хууль тогтоомжид нийцсэн байдал” сэдэвт Ерөнхий хяналтын сонсголын тайлан*

		Л.Эрдэнэбадрах, М.Халтар
Н.Алтаншагай	Үндсэн хуулийн нутгийн өөрөө удирдах ёсны заалтууд; эрх мэдэл өгчихөөд буцаан татах эсэх	Нийслэл, СЯ-ны төлөөлөл
Б.Жаргалан	Урьдчилгаа төлбөрийн эрх зүйн орчин; археологи, палеонтологи, угсаатны судалгааг араас нь хийсэн эсэх; Сэлбэ дэд төв	Б.Гантулга, Б.Одбаяр, Г.Нандинжаргал
О.Батнайрамдал	Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дүгнэлтийг няцаах; Сэлбэ дулаан/цахилгаан/ус хангамж; хувилбар 1, 2-ын хувийн хэвшлийн оролцоо (19.4% эсвэл 60%)	Шинжээч З.Туяа, У.Баатар (Сэлбэ корп.)
Х.Булгантуяа	Сонсголыг санаачилсан 25 гишүүний оролцоо, зохион байгуулалт; улс ба нийслэл/орон нутгийн төсвийн тэгш бус хуваарилалт, реформ	Сонсгол даргалагч, нийслэлийн төлөөлөл
Ц.Баатархүү	Төсөл, төсвийн хэрэгжилт, хяналттай холбоотой асуулт	Нийслэл, холбогдох албадын төлөөлөл
П.Наранбаяр	RFID наалтад зарцуулсан 22.3 тэрбум; 80 / 43 компанийн зөрүү, эрх зүйн үндэслэл; орон нутгаас давсан үйл ажиллагаа	П.Хадбаатар, Ч.Сугармаа (ЗТЯ), М.Халтар, Л.Эрдэнэбадрах

**Дүн:** Хоёр дахь өдрийн асуулт-хариултын хэсэгт нийт 13 гишүүн оролцов.

## ДОЛОО.УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮДИЙН БАЙР СУУРЬ

### 7.1.Засаглал, ашиг сонирхлын зөрчлийн талаар

- Дав.Цогтбаатар, Ч.Лодойсамбуу, Б.Мөнхсоёл нар: НИТХ-ын 45 төлөөлөгчийн дийлэнх нь өмчит компаниудын ТУЗ, гүйцэтгэх удирдлагад ажиллаж, өөрсдөдөө төсөв батлан ажил өгч буй нь Ашиг сонирхлын зөрчлийн тухай хууль болон Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн тухай хуулийн 39.2-ыг зөрчсөн “авлигын сүлжээ” болж буйг хатуу шүүмжилсэн.

- П.Ганзориг (ХҮН намын зөвлөлийн дарга): асуудал нь тогтолцооны гажуудал тул сонгуулийн тогтолцоо (холимог/пропорциональ систем), хотын даргыг иргэдээс шууд сонгох, ИТХ-ын бие даасан байдлыг хангах шаардлагатай.

### 7.2.Нутгийн өөрөө удирдах ёс, төсвийн бодлогын талаар

- Н.Алтаншагай, П.Сайнзориг, О.Батнайрамдал нар: 2022 оноос эхлэн мөрдөж эхэлсэн Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулиар нийслэл санхүүгийн чадамжтай болж, 36 жилийн хуримтлагдсан асуудлыг шийдэх 16 мега төсөл хөдөлсөн нь зөв; орон нутагт өгсөн эрх мэдэлтэй “булаацалдах” биш, хяналтыг зөв тавьж, шаардлагатай бол хуулиа өөрчлөх ёстой. Нийслэлийн бонд гаргах эрх нь хөгжлийн зөв алхам.

- Р.Батболд, Б.Мөнхсоёл, Ж.Баярмаа нар: төсөл хэрэгжүүлэх нь зөв ч санхүүжилтийг төсвийн хууль, сахилга баттай уях ёстой; нийслэлийн төсөвт өртөг хэт өндөр, хяналт сул, засаглалын хямралд орсон.

• Х.Булгантуяа: улс ба орон нутгийн төсвийн хуваарилалт тэгш бус (нийслэлийн сургууль, цэцэрлэг, замыг улсын төсөвт тавихгүй мөртөө сумдын жижиг ажлыг тавьдаг) тул Сангийн яам, Засгийн газар төсвийн реформ хийх шаардлагатай.

### 7.3. Сонсголын зорилго, улс төржилтийн талаар

• П.Сайнзориг, Р.Батболд нар: сонсголыг хэт улс төржүүлж, мега төслүүдийг эрсдэлд оруулж болохгүй; зөрчлийг хууль хяналтын байгууллага шалгана; засаглал, нэгжийн хуулийн алдааг 2022, 2023 онд анхааруулсан ч засаагүй.

• О.Батнайрамдал, Х.Булгантуяа нар: шинжээчдэд хангалттай хугацаа (хуулиар 6 сар хүртэл) өгөх ёстой байсан; ердөө 5 хувийн зарцуулалт, гурван 7 хоногийн дотор 8 тэрбум долларын төсөлд дүгнэлт хийлгэсэн нь хүрэлцээгүй; гэхдээ иргэдийн мэдэх эрхийг хангасан нь зөв.

### НАЙМ.СОНСГОЛ ДАРГАЛАГЧИЙН ДҮГНЭЛТ

Сонсгол даргалагч, Улсын Их Хурлын гишүүн Ж.Золжаргал хоёр өдрийн дүгнэлтдээ дараах гол санааг онцлов:

Тэрээр Ерөнхий хяналтын сонсголыг зохион байгуулах үндсэн шалтгаан нь иргэдийн мэдэх эрх, төрийн байгууллагын мэдээллийн ил тод байдлыг хангах шаардлага байсан гэдгийг онцлов. Сонсголын хүрээнд нийслэлийн төсөв, хөрөнгө оруулалт, мега төслүүдийн хэрэгжилттэй холбоотой олон асуудлыг богино хугацаанд нээлттэй хэлэлцэж, иргэд, төрийн байгууллага, шинжээчдийн байр суурийг сонссон гэж дүгнэв.

Мөн нийслэлийн хэрэгжүүлж буй 16 мега төсөл нь улсын хэмжээнд маш их хэмжээний хөрөнгө, нөөц шаардсан томоохон бүтээн байгуулалтууд бөгөөд эдгээртэй холбоотой маргаан, эргэлзээтэй асуудлуудыг намар хүртэл хойшлуулах боломжгүй, цаг алдалгүй хэлэлцэх шаардлагатай байсан гэж тэмдэглэв.

Сонсгол даргалагч нь сонсголын зорилгыг буруутан тогтоох бус, нийслэлийн томоохон төсөл, хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны талаарх мэдээллийг ил тод болгох, хууль эрх зүйн болон бодлогын түвшний сайжруулалт хийх үндэслэл бүрдүүлэхэд чиглэсэн гэж дүгнэсэн. Тэрээр "бүх зүйл муу байна гэж үзэхгүй, харин сайжруулах шаардлагатай асуудлуудыг тодорхойлж, цаашид засаж сайжруулах хэрэгтэй" гэсэн байр суурийг илэрхийлсэн.

### ЕС.ЕРӨНХИЙ ХЯНАЛТЫН СОНСГОЛЫН НЭГДСЭН САНАЛ, ДҮГНЭЛТ

Хоёр өдрийн сонсголын үеэр танилцуулсан төрийн байгууллагуудын мэдээлэл, шинжээчдийн дүгнэлт, аудитын тайлан, иргэдийн санал, асуулт-хариулт болон холбогдох баримт материалд үндэслэн дараах нэгдсэн дүгнэлтийг гаргаж байна.

1. **Нийслэлийн төсвийн тогтвортой байдал алдагдах эрсдэл нэмэгдсэн байна.** Нийслэлийн төсвийн алдагдал улсын нэгдсэн төсвийн алдагдлаас давсан (232.8%); жилд 4–5 удаа тодотгол хийж байгаа нь Төсвийн тухай хуульд

заасан төсвийн сахилга бат, алдагдалгүй төсөв батлах зарчимтай нийцэхгүй байна. Үнэт цаас, бонд болон гадаад эх үүсвэрээр санхүүжүүлж буй төслүүдийн эргэн төлөлт нь цаашид улсын болон нийслэлийн төсөвт нэмэлт дарамт учруулах эрсдэлтэй байна.

- 2. Хөрөнгө оруулалтын томоохон төслүүдийн төлөвлөлт, бэлтгэл ажил хангалтгүй байна.** Сонсголын үеэр хэлэлцсэн 16 мега төслийн нийт төсөвт өртөг 28,9 их наяд төгрөгт хүрсэн боловч санхүүжилтийн гүйцэтгэл ердөө 5 хувьтай байна. Төсөл, арга хэмжээнүүдийн зарим нь ТЭЗҮ, зураг төсөл, газрын асуудал, техникийн магадлал, байгаль орчны үнэлгээ, олон нийтийн оролцооны шаардлагыг бүрэн хангаагүй байхад батлагдсан нь хэрэгжилт удаашрах, төсөвт өртөг нэмэгдэх, үр ашиг буурах нөхцөлийг бүрдүүлжээ.
- 3. Хууль тогтоомжийн хэрэгжилтэд ноцтой зөрчил илэрсэн байна.** Төсвийн тухай хууль, Захиргааны ерөнхий хууль, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Авлигын эсрэг хууль болон ашиг сонирхлын зөрчилтэй холбоотой хууль тогтоомжийн шаардлагууд бүрэн хангагдаагүй нөхцөл байдал тогтоогдсон байна.
- 4. Нийслэлийн өмчит байгууллагын тоо, чиг үүргийн давхардал нэмэгдэж, засаглалын эрсдэл үүссэн байна.** Сүүлийн жилүүдэд нийслэлийн өмчит болон өмчийн оролцоотой байгууллагын тоо эрчимтэй өсөж, чиг үүргийн давхардал бий болсон төдийгүй төрийн оролцоог нэмэгдүүлж, хувийн хэвшлийн өрсөлдөөний орон зайг хязгаарлах нөхцөл үүсчээ. НИТХ-ын төлөөлөгчид өмчит байгууллагын удирдлага, ТУЗ-д ажиллаж, тухайн байгууллагын төсөв, хөрөнгө оруулалтыг хэлэлцэн баталж байгаа нь ашиг сонирхлын зөрчил үүсгэх өндөр эрсдэлтэй байна.
- 5. Иргэдийн оролцоо, олон нийтийн хэлэлцүүлэг хангалтгүй байна.** Томоохон төсөл, хөрөнгө оруулалтын шийдвэр гаргах үйл ажиллагаанд иргэдийн оролцоог бодитой хангаагүй, олон нийтийн хэлэлцүүлгийг шийдвэр гарсны дараа зохион байгуулсан, эсхүл хуульд заасан төлөвлөлтийн сонсголыг зохих журмын дагуу хэрэгжүүлээгүй тохиолдлууд илэрсэн байна.
- 6. Ил тод байдал, мэдээллийн хүртээмж хангалтгүй байна.** Нийслэлийн төсөв, мега төслүүдийн хэрэгжилт, санхүүжилт, гүйцэтгэгч байгууллага, гэрээ, зарцуулалтын талаарх мэдээлэл иргэдэд бүрэн нээлттэй биш байгаа нь иргэдийн мэдээлэл авах эрх болон олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх боломжийг хязгаарлаж байна.
- 7. Санхүүжилтийн эх үүсвэрийн бодит эрсдэл өндөр байна.** Мега төслүүдийн нийт санхүүжилтийн 54 орчим хувийг гадаад зээл, үнэт цаас болон бусад өрийн хэрэгслээр санхүүжүүлэхээр төлөвлөсөн боловч эх үүсвэрүүд бүрэн баталгаажаагүй, зарим төслийн эдийн засаг, санхүүгийн үр өгөөжийн тооцоолол бодитой бус, хэт өөдрөг таамаглалд тулгуурласан нь хэрэгжилтийн болон өрийн эрсдэлийг нэмэгдүүлж байна.
- 8. Худалдан авах ажиллагаа болон урьдчилгаа санхүүжилттэй холбоотой ноцтой эрсдэл илэрсэн байна.** Туулын хурдны замын төслийн тендер

шалгаруулалт, гэрээ байгуулах ажиллагаанд шаардлага хангаагүй баримт бичиг, эрх зүйн зөрчил, санхүүгийн баталгаатай холбоотой асуудлууд илэрсэн бөгөөд төслийн хүрээнд олгосон их хэмжээний урьдчилгаа санхүүжилтэд хууль хяналтын байгууллагууд мөрдөн шалгах ажиллагаа явуулж байна. Тухайлбал, 500 тэрбум төгрөгийн урьдчилгааг эргэлзээтэй баталгаагаар олгосон; 8 хүн яллагдагчаар татагдаж, 3 хүн цагдан хоригдсон, 2,6 их наяд төгрөгийн гүйлгээ хязгаарлагдсан.

9. **Хяналт, хариуцлагын тогтолцооны үр нөлөө хангалтгүй байна.** Аудитын байгууллагаас өгсөн зөвлөмжүүд бүрэн хэрэгжихгүй байгаа, хууль тогтоомжийн зөрчилд холбогдох байгууллага, албан тушаалтнуудад хариуцлага тооцох механизм сул байгаа нь ижил төрлийн зөрчил давтагдах нөхцөлийг бүрдүүлж байна.

## ЦААШИД АВАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ САНАЛ

1. **Төсвийн сахилга бат, тогтвортой байдлыг хангах чиглэлээр** Төсвийн тухай хуульд заасан төсвийн тэнцвэрт байдлын шаардлагыг чанд мөрдүүлж, төсвийн алдагдал болон өрийн удирдлагад тавих хяналтыг сайжруулах, орон нутгийн төсвийн өмнөх оны үлдэгдлийг тухайн жилийн дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл болон төсвийн тэнцэл, алдагдлын тооцоонд шууд нөлөөлдөг одоогийн аргачлалыг шинэчлэн боловсронгуй болгож, холбогдох хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах. Мөн аж ахуйн нэгжийн орлогын албан татварын орон нутгийн төсөвт хуваарилах хувь хэмжээ, аргачлал болон төсвийн зохицуулалтын тогтолцоотой уялдах байдлыг судалж, аймаг, нийслэлийн санхүүгийн чадавхын ялгааг бууруулах, төрийн үйлчилгээний тэгш хүртээмжийг хангах, нэгдсэн төсвийн тогтвортой байдлыг хамгаалах чиглэлээр эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох.

2. **Төсөл, арга хэмжээ батлах урьдчилсан шалгуурын тогтолцоог бүрдүүлэх чиглэлээр** ТЭЗҮ, зураг төсөл, газрын асуудал, техникийн магадлал, байгаль орчны үнэлгээ, олон нийтийн сонсгол, санхүүжилтийн эх үүсвэрийн баталгааг бүрэн хангаагүй төсөл, арга хэмжээг төсөвт тусгахгүй байх хууль, тогтоомжийн хэрэгжилтийн хянах, эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох;

3. **Мега буюу эдийн засаг, нийгмийн томоохон нөлөө үзүүлэхүйц төслүүдийн эдийн засаг, санхүүгийн үнэлгээг сайжруулах чиглэлээр** эдийн засаг, санхүүгийн шинжилгээг нэгдсэн аргачлал, стандартаар боловсруулах, төслүүдийг нийгэм, эдийн засгийн үр өгөөж, төсөвт үзүүлэх нөлөө, эрсдэлийн үнэлгээнд үндэслэн эрэмбэлж сонгон хэрэгжүүлэх, төслийн хамрах хүрээ, онцлогоос хамаарч улсын ба орон нутгийн түвшинд хэрэгжүүлэх талаар илүү тодорхой тогтолцоог бүрдүүлэх;

4. **Нийслэлийн өмчит байгууллагын засаглалыг сайжруулах чиглэлээр** өмчит болон өмчийн оролцоотой байгууллагуудын чиг үүргийн давхардал, хэрэгцээ, үр ашгийг дахин үнэлж, бүтцийн оновчлол хийх, төрийн оролцоог бууруулж хувийн хэвшлийн өрсөлдөх боломжийг нэмэгдүүлэх;

5. **Ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр** НИТХ-ын төлөөлөгчдийн өмчит компаниудын удирдлага, ТУЗ-д ажиллах, тухайн байгууллагын төсөв, хөрөнгө оруулалтын асуудлыг хэлэлцэн шийдвэрлэхтэй холбоотой ашиг

сонирхлын зөрчлийг хуульчлан зохицуулж, татгалзан оролцох болон мэдүүлгийн тогтолцоог ил тод хэрэгжүүлэх, иргэдийн төлөөлөгчдийн хурлын Төлөөлөгчдийг хараат бус байдлаар ажиллах нөхцөлийг бүрдүүлэх;

**6. Иргэдийн оролцоог бодитой хангах чиглэлээр** томоохон төсөл, хөрөнгө оруулалтын шийдвэр гаргахаас өмнө Захиргааны ерөнхий хуульд заасан төлөвлөлтийн сонсгол, олон нийтийн хэлэлцүүлгийг заавал зохион байгуулж хэвших, иргэдийн санал, дүгнэлтийг шийдвэр гаргалтад тусгах эрх зүйн болон зохион байгуулалтын механизмыг боловсронгуй болгох;

**7. Ил тод байдлыг нэмэгдүүлэх чиглэлээр** нийслэлийн төсөв, хөрөнгө оруулалтын төсөл, санхүүжилт, гэрээ, худалдан авах ажиллагаа, гүйцэтгэлийн мэдээллийг нэгтгэсэн нээлттэй цахим системийг хөгжүүлж, иргэдийн мэдээлэл авах эрхийг бүрэн хангах;

**8. Худалдан авах ажиллагааны хяналтыг сайжруулах чиглэлээр** тендер шалгаруулалтын баримт бичиг, үнэлгээ, гэрээ байгуулах ажиллагаанд тавих хяналтыг сайжруулж, урьдчилгаа төлбөр олгох нөхцөл, баталгааны шаардлагыг чангатгах;

**9. Аудит, хяналт шалгалтын мөрөөр хариуцлага тооцох чиглэлээр** аудитын байгууллага болон хяналтын байгууллагын зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байгууллага, албан тушаалтанд хуульд заасан хариуцлагыг заавал тооцдог тогтолцоог бүрдүүлэх;

**10. Эрх зүйн орчныг боловсронгуй болгох чиглэлээр** Төсвийн тухай хууль, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хууль, Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжид шаардлагатай нэмэлт, өөрчлөлтийг боловсруулж хэлэлцүүлэх;

**11. Сонсголын мөрөөр хэрэгжүүлэх арга хэмжээний хүрээнд ажлын хэсгийн санал, дүгнэлтийг боловсруулж Төсвийн байнгын хороогоор хэлэлцүүлэн, шаардлагатай тохиолдолд Улсын Их Хурлын тогтоолын төсөл боловсруулж нэгдсэн чуулганаар хэлэлцүүлэх.** Сонсголын үеэр үнэн зөв мэдээлэл өгөөгүй, парламентыг хүндлээгүй зөрчил гаргасан тохиолдлуудад санал дүгнэлт боловсруулж холбогдох албан тушаалтанд хариуцлага тооцох;

**12. Үр дүнгийн хяналтын тогтолцоог бэхжүүлэх чиглэлээр** томоохон төсөл, хөрөнгө оруулалтын хэрэгжилтэд зориулсан үр дүнгийн хяналтын сонсголыг тогтмол зохион байгуулж, шийдвэрийн хэрэгжилтэд парламентын хяналтыг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх шаардлагатай байна.

ТӨСВИЙН БАЙНГЫН  
ХОРООНЫ ДАРГА

Н.НАРАНБААТАР

### Хавсралт. Асуулт-хариултын тоон нэгтгэл

Сонсгол даргалагч (Ж.Золжаргал) хуулиар асуулт асуудаггүй, зөвхөн асуулт-хариултыг чиглүүлэн тодруулдаг тул дараах тоон мэдээлэл нь асуулт-хариултын хэсэгт оролцож, бусад оролцогчоос асуулт асуусан УИХ-ын гишүүдийг хамруулсан болно.

Үзүүлэлт	Тоо
Сонсголын нийт өдөр	2 өдөр (06.15, 06.16)
Эхний өдөр асуулт асуусан УИХ-ын гишүүн	9 гишүүн
Хоёр дахь өдөр асуулт асуусан УИХ-ын гишүүн	13 гишүүн
Хоёр өдөрт асуулт асуусан давхардаагүй гишүүн	15 гишүүн
Хоёр өдөр хоёуланд нь асуусан гишүүн	7 гишүүн
Асуултад хариулсан байгууллага/албан тушаалтан (нийт, давхардаагүй)	25 орчим

**Давхардаагүй 15 гишүүн:** Дав.Цогтбаатар, Ч.Лодойсамбуу, Б.Мөнхсоёл, Н.Алтаншагай, Р.Батболд, П.Ганзориг, П.Сайнзориг, Ж.Баярмаа, О.Батнайрамдал (эхний өдөр); Д.Үүрийнтуяа, Д.Энхтүвшин, Б.Жаргалан, Х.Булгантуяа, Ц.Баатархүү, П.Наранбаяр (хоёр дахь өдөр шинээр нэмэгдсэн).

**Хоёр өдөр хоёуланд нь асуусан 7 гишүүн:** Р.Батболд, Б.Мөнхсоёл, Дав.Цогтбаатар, П.Сайнзориг, Ж.Баярмаа, Н.Алтаншагай, О.Батнайрамдал.

**Хариулт өгсөн гол байгууллага, албан тушаалтан:** НЗД Б.Пүрэвдагва, орлогч Б.Мөнхбат; Нийслэлийн Замын хөгжлийн газрын дарга Б.Одбаяр; НЗДТГ-ын Л.Эрдэнэбадрах, Б.Гантулга, П.Хадбаатар; НИТХ-ын М.Халтар; “Сэлбэ 20 минутын хот” корп. У.Баатар; Эмээлт парк Б.Мягмар; НТУГ Э.Түвшинжаргал; “УБ хөрөнгө оруулалт менежмент” Г.Гангамөрөн; АТГ-ын Г.Азжаргал, М.Даваатогтох; Сангийн яамны М.Санжаадорж; ЭХЯ-ны И.Лувсанцэрэн; ЗТЯ-ны Ч.Сугармаа; ЗТХТ Д.Оюунболд; БХТ З.Энх-Оргил; ТХААГ Ц.Батзул; Ерөнхий аудитор С.Магнайсүрэн, ҮАГ Б.Батчимэг, Нийслэл аудит Г.Нандинжаргал; БОУАӨЯ А.Алтанзул; шинжээч Д.Энхбаяр, З.Туяа болон бусад.

*Тайлбар: Энэхүү танилцуулга нь 2026 оны 06 дугаар сарын 15, 16-ны өдрийн сонсголын дэлгэрэнгүй тэмдэглэлд үндэслэв. Асуулт-хариултын тоон мэдээлэл нь тэмдэглэлд бичигдсэн илтгэгчийн дараалал, асуулт асуусан гишүүдийн оролцоонд тулгуурлан гаргасан болно.*